20.22 Immunization coverage for infants, by immunization	362
20.23 Income and expenditure of social welfare services	363
20.24 Number of persons who received social welfare benefits and assistance, by type	364
20.25 Pension provided by the social insurance fund, by type of pension	364
20.26 Number of insured person to the social insurance, social insurance fund income	364
20.27 Child malnourishment, by sex, location and age group, in 2000 and 2005	365
20.28 Household consuming iodized salt, by residence, location and education of household head in 2000 and 2005	365
20.29 Children aged 6-59 months, received high dose vitamin "A" supplement, by sex, location and age group, in 2000 and 2005	366
20.30 Mothers received a high dose vitamin "A" supplement after given birth, by residence, location and education level, in 2000 and 2005	366
20.31 Knowledge of preventing hiv transmission, by residence, location and educational level, in 2000 and 2005	367
20.32 Women aged 15-49 years, identified miscon about HIV/AIDS, by region, location and education level, in 2000 and 2005	367
20.33 Comprehensive knowledge of HIV/AIDS transmsion, by residence, location and education level, in 2000 and 2005	368
20.34 Knowledge of mother-to-child HIV transmission, by residence, location and educational level, in 2000 and 2005	368
20.35 Attitudes toward people living with HIV/AIDS, by residence, location, age and education level, in 2000 and 2005	369
20.36 Knowledge of a facility for HIV testing, by residence, location and educational level, in 2000 and 2005	369

SECTION 21. CRIME	371
21.1 Number of offences committed, by type of offences	372
21.2 Number of sentenced persons	372
21.3 Number of crime against human life and health, by regions, aimags and the Capital	373
21.4 Number of crime against child, family and fabric of society, by regions, aimags and the Capital	374
21.5 Number of crime against social safety, by regions, aimags and the Capital	375
21.6 Number of crime against traffic safety and use, by regions, aimags and the Capital	376
21.7 Number of crime against economic entity, by regions, aimags and the Capital	377
21.8 Number of crime against ownership right, by regions, aimags and the Capital	378
21.9 Number of theft of cattle, by regions, aimags and the Capital	379
21.10 Number of offences committed, by regions, aimags and the Capital	380
21.11 Number of persons sentenced, by regions, aimags and the Capital	381
21.12 Number of persons sentenced, by educational level	381
21.13 Number of persons sentenced, by age group	381
21.14 Number of offences per 10000 population of age 18 and above	382
21.15 Number of offenders, by regions, aimags and the Capital.	383
21.16 Crime caused of damage, billion togrogs	383
SECTION 22. NATURE AND ENVIRONMENT	386
22.1 Annual average temperature, by aimags and the Capital	387
22.2 Land classification of Mongolia	387
22.3 Life forms of vascular plants, 1989	387
22.4 Composition of vascular and lower plants of Mongolia, in 1998	388
22.5 Total rainfall and number of days with rainfall, by aimags center and the Capital	388
22.6 Multi year mean indicators of climate, by aimags and the Capital	389
22.7 Number of forest fires, by times and fire affected, regions, aimags and the Capital	390
22.8 Forest harvest volume, by regions, aimags and the Capital	391
22.9 Capital investment for protection and rehabilitation of natural resources	391
22.10 Maximum limit of hunting wild animals for domestic purpose, 2008, by regions, and aimags, hunting animals	392
22.11 Land degradation	393
22.12 Report of the surface water, by regions, aimags and the Capital, by years of census conducted	393
22.13 Annual average concentration of pollution in air, by aimags center and the Capital, in 2007	394
22.14 Annual average concentration of pollution in air in Ulaanbaatar, by the Capital's stations, in 2007	395
22.15 Amount of pollution permissible in the air concentration	395
22.16 Disasters occurred and the damages	395
SECTION 23. PRODUCTIVITY	398
23.1 Total productivity, by divisions, at current prices	399
23.2 Total factor productivity, by divisions, at current prices	399
23.3 Labour productivity, by divisions, at 2005 constant prices	340
23.4 Capital productivity, by divisions, at current prices	340
23.5 Raw material productivity, by divisions, at current prices	401
23.6 Electricity productivity, by divisions, at current prices	401
SECTION 24. BUSINESS REGISTER	403
24.1 Number of establishments in the business register, by aimags and the Capital, at the end of the year	404
24.2 Number of establishments by sectors of economic activities, at the end of the year	405
24.3 Number of establishments by employment size class, at the end of the year	406
24.4 Number of establishments, by type, at the end of the year	406
24.5 Number of active establishments, by aimags and the Capital, at the end of the year	407
24.6 Number of active establishments, by sectors of economic activities, at the end of the year	408
24.7 Number of active establishments, by employment size class, at the end of the year	408
24.8 Number of registered establishments in the Capital city, by districts, at the end of the year	409

SECTION 25.HUMAN DEVELOPMENT INDEX	411
25.1 Human development index, by regions, aimags and the Capital	412
25.2 Gender development index, by regions, aimags and the Capital	413
25.3 Gender empowerment measure, by regions, aimags and the Capital	414
SECTION 26. INDICATORS OF MILLENNIUM DEVELOPMENT GOALS	416
25.1 Indicators of millennium development goals	417
SECTION 27. WORLD DEVELOPMENT INDICATORS	422
27.1 Size of economy, as of 2005	422
27.2 Integration with the global economy, % of GDP	426
27.3 Distribution of net aid by development assistance committee members, 2005, by regions	427
27.4 Official development aid dependency, by some selected countries of the regions	428
27.5 Structure of output, by some selected countries of the regions	429
27.6 Structure of final demand, by some selected countries of the regions	430
27.7 International trade, selected countries of the regions	431
27.8 Implementation of millennium development goals, by some selected countries of the regions	432

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**Хүн ам**

Монгол Улсын суурин хүн амын тоо 2007 оны жилийн эцсийн байдлаар 2635.2 мянга болж, 2006 оныхоос 1.6 хувь буюу 40.4 мянган хүнээр өслөө. Нийт хүн амын 48.7 хувь нь эрэгтэйчүүд, 51.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд 100 эмэгтэйд 95.1 эрэгтэй ногдож байна.

Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөний урсгал их байгаа нь нийслэл хотын хүн ам жил ирэх тутам хурдтай өсөх нөхцөл болж байна. 2007 оны байдлаар нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүн амын тоо Улаанбаатар хотод 219.4 хүн ногдох болж 2004 оныхоос 11.0 хувь, 2005 оныхоос 6.8 хувь, 2006 оныхоос 3.7 хувиар нэмэгджээ.

Улсын дүнгээр авч үзэхэд 2007 онд нийт хүн амын 60.8 хувь буюу 1601.0 мянган нь хот, тосгонд амьдарч байгаагаас Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгийн хүн амын талаас илүү хувь нь хот, тосгонд оршин сууж байгаа бол Төв аймгийн хүн амын 80 гаруй хувь нь хөдөөд амьдарч байна.

Улсын хэмжээнд 2007 оны байдлаар 645.7 мянган өрх, түүний 59.1 хувь нь хотод, 40.9 хувь нь хөдөөд байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 4.1 хүн ногдож байна.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд хүн амын жилийн цэвэр өсөлт буурах хандлага ажиглагдаж байсан ч 2006, 2007 онуудад төрөлт нэмэгдэж 1000 хүн амд ногдох төрөлт 2007 онд 21.7 болж, 2006 оныхоос 2.7 пунктээр нэмэгдэв. 2007 онд нийт төрсөн хүүхдийн тоо 56.6 мянгад хүрч 2004 оныхоос 24.5 хувь, 2006 оныхоос 15.4 хувиар өсчээ. Манай улсын төрөх үеийн хүйсийн харьцаа олон улсын дундаж түвшингийн ойролцоо болж, 100 охидод 103 хөвгүүд ногдож байна. Төрөлтийн нийлбэр коэффициент 2004 онд 2.0, 2005 онд 1.9; 2006 онд 2.1 байсан бол 2007 онд 2.3 болжээ.

Манай улсын хүн амын нас баралтын ерөнхий коэффициент сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байсан бол харин 2007 онд 6.2 болж 2006 оныхоос 0.3 пунктээр буурлаа. Нэг нас хүрээгүй хүүхдийн эндэгдэл буюу нялхсын нас баралтын коэффициент аажмаар буурч байна. 2007 онд нийт 16.3 мянган хүн нас барсны 6.1 хувийг нялхсын нас баралт эзэлж байна. 1000 хүн амд ногдох нас баралт аймгуудын хувьд харилцан адилгүй байгаа бөгөөд 2007 оны байдлаар Хөвсгөл(7.1), Дархан-Уул(6.9), Хэнтий(6.8), Орхон(6.8) аймагт хамгийн өндөр, Өмнөговь(4.3), Баян-өлгий(4.9), Ховд(5.0), Дорноговь(5.4) аймагт хамгийн бага байна.

Нийт 41.0 мянган хос 2007 онд гэрлэлтээ бүртгүүлж, 1.8 мянган гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 2.5 мянган хүүхдийг үрчилж авчээ. Гэр бүл цуцлалт 2006 оныхоос 21.3 хувь, хүүхэд үрчлэлт 19.6 хувиар нэмэгдсэн байна. Харин 1000 хүн амд ногдох гэрлэлт 2004-2006 онд тогтвортой өсч байснаа 2007 онд 2006 оныхоос 3.3 пунктээр буурсан байна.

1000 хүнд ногдох гэр бүл цуцлалтын чиг хандлага харьцангуй тогтворгүй байгаа бөгөөд 2005 онд 2004 оныхоос 0.3 пунктээр өссөн, бол 2006 онд 2005 оныхоос 0.4 пунктээр буурсан, харин 2007 онд 2006 оныхоос 0.1 пунктээр өссөн дүн гарлаа.

Хүн ам, нийгмийн зарим үзүүлэлт

Монгол улсын төрөөс эх, хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг онцгойлон анхаарч холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Улсын хэмжээгээр өнчин хүүхдийн тоо 2007 онд 49.8 мянгад хүрч 2004 оныхоос 3.7 хувь, 2005 оныхоос 5.3 хувь, 2006 оныхоос 2.4 хувиар буурч, жил тутам буурах хандлагатай байна. Нийт өнчин хүүхдийн 10.2 хувь буюу 5.1 мянга нь бүтэн өнчин, 89.8

хувь буюу 44.7 мянга нь хагас өнчин хүүхдүүд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо 2004 оныхоос 6.5 хувиар өссөн хэдий ч, 2005 оныхоос 6.8 хувь, 2006 оныхоос 3.8 хувь, мөн хагас өнчин хүүхдийн тоо 2004 оныхоос 3.4 хувь, 2005 оныхоос 5.1 хувь, 2006 оныхоос 2.3 хувиар тус тус буурлаа.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2007 онд 72.1 мянга болж 2004 онтой харьцуулахад 9.8 хувь, 2005 оныхоос 2.6 хувиар өссөн бол 2006 оныхоос 0.1 хувиар буурчээ. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тооны өсөлтөд 18 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн нас баралт гэр бүл цуцлалтаас илүү нөлөөлж байна.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 50.9 хувь буюу 36.7 мянга нь 3 хүртэл; 37.4 хувь буюу 27.0 мянга нь 3-5; 11.7 хувь буюу 8.4 мянга нь 6 ба түүнээс дээш ам бүлтэй байна. 2007 оны байдлаар өрх толгойлсон нийт эмэгтэйчүүдийн 14.7 хувь нь Баруун бүсэд, 24.2 хувь нь Хангайн бүсэд, 19.1 хувь нь Төвийн бүсэд, 9.7 хувь нь Зүүн бүсэд, 32.3 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Улсын хэмжээнд 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 2007 онд 37.9 мянга болж, 2004 оныхоос 18.8 хувь, 2005 оныхоос 10.6 хувь, 2006 оныхоос 5.2 хувиар буурчээ. Харин 16 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо 2007 онд 43.5 мянга болж, 2004 оныхоос 3.5 хувь, 2005 оныхоос 10.1 хувь, 2006 оныхоос 5.8 хувиар буурсан байна. 16 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүдийн 61.3 хувь буюу 26.7 мянга нь 3 хүртэл; 28.2 хувь буюу 12.3 мянга нь 3-5; 10.5 хувь буюу 4.6 мянга нь 6 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй байна.

Ажиллах хүч

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлснээр тус улсын эдийн засагт бүтцийн өөрчлөлт, үйлдвэрлэлийн уналт, аж ахуйн нэгжүүдийн өөрчлөн байгуулалт явагдаж улмаар ажил орлогогүй иргэдийн тоо нэмэгдэх болсон ба тэднийг шинэ ажил үйлчилгээнд зуучлах, мэргэжил олгох зэрэг асуудал чухлаар тавигдсан юм. Энэ үеэс хөдөлмөр зохицуулалтын албадууд байгуулагдаж эхэлсэн. 1992 оноос олон улсын стандарт аргачлалын дагуу хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (хөдөлмөр эрхлэлтийн алба)-т бүртгэлтэй хүмүүсийг ажилгүйчүүд гэж үзэж улсын хэмжээний ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам; ажиллах хүчний оролцоо, ажилгүйдлийн түвшний үзүүлэлтийг тооцон гаргаж статистикийн мэдээлэлд хамруулдаг болов.

Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхитэй байдлыг харуулдаг гол үзүүлэлт бол ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин бөгөөд энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд бага зэрэг буурч ирсэн. Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин 2007 онд 64.2 хувь болж 2004, 2006 оныхоос тус тус 0.2 пунктээр буурч, харин 2005 оныхоос 0.7 пунктээр нэмэгдэв. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2007 онд 29.9 мянган хүн болж 2004 оныхоос 15.8 хувь, 2005, 2006 оныхоос тус бүр 9.1 хувиар буурчээ. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо сүүлийн жилүүдэд буурсаар байгаа нь ажиллагчдын тоо өсч байгаагаас гадна аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (хөдөлмөр эрхлэлтийн алба)-ээр зуучлуулан ажилд орсон ажилгүй хүмүүсийн тоо нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Манай улсын хэмжээгээр эдийн засгийн идэвхитэй хүн амд нийт ажиллагчдын эзлэх хувь 2007 онд 97.2 хувь болж 2004 оныхоос 0.8 пунктээр, 2005 оныхоос 0.5 пунктээр, 2006 оныхоос 0.4 пунктээр нэмэгджээ.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, боловсруулах аж үйлдвэр, үл хөдлөх хөрөнгө, бизнесийн бусад үйл ажиллагаа, нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээний салбарынхаас бусад бүх салбарт ажиллагчдын тоо өссөн байна.

Товч танилцуулга |

Эдийн засгийн идэвхитэй хүн ам болон ажиллагчдын дотор эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байгаа бол харин бүртгэлтэй ажилгүйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байна.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн дотор дээд боловсролтой болон мэргэжилгүй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэж, тусгай дунд болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгссөн хүмүүсийн эзлэх хувь буурч байна.

Монгол улсын төрийн албанд 2007 оны 1 сарын 1-ний байдлаар 128.1 мянган албан хаагч ажиллаж байгаа нь 2004 оныхоос 1.3 хувь, 2005 оны оныхоос 5.2 хувь, 2006 оныхоос 6.2 хувиар тус тус нэмэгджээ.

Дундаж цалин

Ажиллагчдын дундаж цалингийн түүвэр судалгааг 2000 оны 4 дүгээр улирлаас эхлэн улирал тутам улсын хэмжээгээр явуулж дүнг хүйс, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн болон хариуцлагын хэлбэрээр, аймаг, нийслэлээр гаргаж байна. Түүвэр судалгаанд улиралд дунджаар 1035 аж ахуйн нэгж, байгууллагын 163.0 мянган ажиллагчид хамрагдаж байна.

Ажиллагчдын дундаж цалин 2007 онд 173.0 мянган төгрөг байгаа нь 2004 оныхоос 85.8 хувь, 2005 оныхоос 70.9 хувь, 2006 оныхоос 35.5 хувиар өсөв.

Сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд тээвэр, агуулахын аж ахуй, холбоо, боловсрол, төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал, уул уурхай, олборлох аж үйлдвэр, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа зэрэг салбарт ажиллагчдын дундаж цалин бусад салбарын ажиллагчдынхаас болон улсын дунджаас өндөр байна. Түүнчлэн төрийн өмчит үйлдвэрийн газрын ажиллагчдын сарын дундаж цалин улсын дундаж болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдынхаас харьцангуй өндөр байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол Улсын эдийн засгийн байдалд нааштай хандлагууд гарч, сүүлийн жилүүдэд эдийн засгийн харьцангуй өндөр өсөлт хадгалагдаж ирлээ. Эдийн засгийн бодит өсөлт 2000-2003 онд жилд дунджаар 4.3 хувь өсч байсан бол 2004-2007 онд жилд дунджаар 9.1 хувь өссөн байна.

2004-2007 оны дундаж өмнөх 4 жилийн дунджаас 4.8 пунктээр өндөр гарахад малын тоо 2003 оноос 14.9 сая толгойгоор өссөн, олборлосон алтны хэмжээ жилд дунджаар 20.9 тн болж, 2000-2003 оныхоос жилд дунджаар 8.7 тонноор нэмэгдсэн, сүүлийн жилүүдэд мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт 2 аж ахуйн нэгж шинээр үүрэн телефон холбооны операторын үйл ажиллагаа явуулж эхэлсэн, боловсруулах аж үйлдвэрийн төмрийн үйлдвэрлэлийн салбарт молибденийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аж үйлдвэр, хөдөө аж ахуйн зарим гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл мэдэгдэхүйц өслөө. Тухайлбал, аж үйлдвэрийн салбарын сүлжмэл эдлэл, нүүрс, алт, самнасан ноолуур зэрэг бүтээгдэхүүний 2004-2007 оны дундаж үйлдвэрлэл 41.6-86.8 хувиар, газар тариалангийн салбарт хүнсний ногоо, төмсний үйлдвэрлэл дунджаар 38.4-56.1 хувиар нэмэгдсэн байна.

Нэг хүнд ногдох ДНБ (2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлсэн)-ний 2000-2003 оны жилийн дундаж хэмжээ 885.7 мянган төгрөг байсан бол 2004-2007 оны жилийн дундаж хэмжээ 1140.1 мянган төгрөгт хүрч, 1.3 дахин нэмэгдлээ.

ДНБ 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 4557.5 тэрбум төгрөг болж, 2006 онтой харьцуулахад 9.9 хувь буюу 299.1 тэрбум төгрөгөөр өссөн. ДНБ-ий энэхүү өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 2006 оныхоос 15.8 хувь, боловсруулах үйлдвэрийн салбарынх 32.3 хувь, барилгын салбарынх 22.4 хувь, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарынх 18.6 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Хувийн хэвшил 1995 онд ДНБ-д 52.6 хувийг эзэлж байсан бол 2007 онд 68.4 хувь болж эдийн засагт хувийн хэвшил давамгайлах байр суурьтай боллоо.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий 2007 оны урьдчилсан гүйцэтгэлийн бүтцийг авч үзвэл эцсийн хэрэглээ 64.1 хувь, нийт хуримтлал 37.6 хувь, цэвэр экспорт (-1.7) хувь болж, 2006 онтой харьцуулахад ДНБ-д эцсийн хэрэглээ болон нийт хуримтлалын эзлэх хувь 2.8-4.5 пунктээр тус тус өсч, харин цэвэр экспортын эзлэх хувь хэмжээ 7.3 пунктээр буурсан байна. Бүтцийн энэ өөрчлөлт нь 2007 онд цэвэр экспорт буюу бараа, үйлчилгээний тэнцэл алдагдалтай гарснаас голлон шалтгаалжээ. Бараа, үйлчилгээний тэнцэл алдагдалтай гарахад барааны импортын өсөлт экспортын өсөлтөөс илүү хурдацтай байсан, мөн тээврийн болон даатгалын үйлчилгээний зардал өссөн, барилга угсралтын ажил эрчимжсэн зэрэг нь нөлөөлжээ.

ДНБ-ийг улирлаар тооцох аргачлал 2007 онд батлагдсан. ДНБ-ий өсөлтийг улирлаар харьцуулахад 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2 дугаар улиралд өмнөх улирлаасаа 55.4 хувь, 3 дугаар улиралд 2.2 хувь, 4 дүгээр улиралд 11.4 хувиар тус тус өссөн байна.

Салбар хоорондын тэнцэл

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр макро эдийн засгийн гол үзүүлэлт, тооцооны аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилт тавигдаж, сүүлийн жилүүдэд ДНБ-ийг тооцох аргыг шуурхай нэвтрүүлэх, үндэсний тооцооны дансууд байгуулах зэрэг асуудлаар багагүй ажил хийж байна.

Үүний зэрэгцээ улс орны эдийн засгийн үндсэн тэнцвэрийг макро түвшинд нэгтгэн, тэнцэл хэлбэрээр харуулах Салбар хоорондын тэнцлийг тодорхой хугацаанд тогтмол давтамжтайгаар байгуулж, гарсан үр дүнд дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулагчдад ашиглах мэдээллийн эх үүсвэрийг улам дэлгэрэнгүй харилцан уялдаатай болгох нь Үндэсний Статистикийн Хорооны чухал зорилтын нэг юм.

Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцааны тогтолцоогоор хөгжиж байхдаа 1963 оноос салбар хоорондын тэнцлийг зохиож ирсэн түүхтэй. Тухайн үед эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн гишүүн орнуудад мөрдөж байсан Улс ардын аж ахуйн баланс зохиох аргыг хэрэглэж Салбар хоорондын тэнцлийг 1966, 1970, 1977, 1983, 1987 онуудын гүйцэтгэлээр зохиосон билээ. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш Үндэсний тооцооны систем (ҮТС'93)-ийн нийтлэг арга зүйг мөрдлөг болгон салбар хоорондын тэнцлийг 1997 болон 2000 онд туршилтын журмаар, энэ удаагийн 2005 оны салбар хоорондын тэнцлийг нөөц, ашиглалтын тэнцэлд үндэслэн зохиов.

Эдийн засгийн нөөц. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт нөөцийн хэмжээ худалдан авагчийн үнээр 2005 онд 7741.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Цахилгаан, дулааны эрчим хүч, мал, малын гаралтай түүхий эд, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, металлын хүдэр, нүүрс зэрэг бүтээгдэхүүний 72.4-94.9 хувийг дотоодын үйлдвэрлэлтээр, харин металл бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, шатахуун, тамхи, цаас, цаасан бүтээгдэхүүний нөөцийг үндсэндээ импортоор хангаж байна. Үүнээс

Товч танилцуулга |

үзвэл мал, малын гаралтай бүтээгдэхүүн, нүүрс, эрчим хүч, мах, махан бүтээгдэхүүн болон сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг үндсэнд нь өөрийн үйлдвэрлэлтээр хангаж, химийн бүтээгдэхүүн, шатахуун, металл бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмжийн хувьд гадаадаас бүрэн хамааралтай байна. Салбарын бүтээгдэхүүний нөөцөд тээвэр, худалдааны нэмэгдэл нэлээд чухал хүчин зүйл болох нь харагдаж байна. Тухайлбал, тээвэр, худалдааны нэмэгдэл хүнсний бүтээгдэхүүний ашиглах нөөцийн 11.9-21.6 хувь, арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний 18.9 хувь, шатахуун, металл бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, шил, шилэн бүтээгдэхүүн, бусад төмөрлөг бус бүтээгдэхүүн, химийн бүтээгдэхүүн зэрэг импортын бүтээгдэхүүний 12.2-20.4 хувийг тус тус эзэлж байна.

Нийт нөөцийн 61.8 хувийг бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, 38.2 хувийг үзүүлсэн ажил, үйлчилгээний нийлүүлэлт эзэлж байна. Энэ нь манай орны эдийн засагт үйлчилгээний салбарын эзлэх байр суурь улам өргөжиж буйг харуулж байна.

Дотоодын үйлдвэрлэлтийн 45.5 хувийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, үүний дотор 16.2 хувийг уул уурхай, олборлох салбарын бүтээгдэхүүн, 10.8 хувийг мал, малын гаралтай бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн (түүхий эд); үйлчилгээний салбаруудын үйлдвэрлэлт 54.5 хувийг эзэлж байна.

Үйлдвэрлэлийн салбарын бүтцээс авч үзвэл мал аж ахуй, уул, уурхай олборлох салбарууд эдийн засгийн хувьд тэргүүлэх салбар хэвээрээ, харин боловсруулах чиглэлийн салбар төдийлөн хөгжихгүй байгаа нь хадгалагдсаар байна.

Импортын бүтээгдэхүүн, үйлчилгээний 70.3 хувийг бүтээгдэхүүний импорт, үүний дотор 27.3 хувийг металл бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмжийн, 17.8 хувийг шатахууны, 2.0 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна. Үйлчилгээний импорт 29.7 хувьтай байна.

Нөөцийн ашиглалт. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт нөөцийн 35.7 хувь нь завсрын хэрэглээнд, 28.8 хувь нь эцсийн хэрэглээнд, 14.7 хувь нь хуримтлал бий болгоход, 20.7 хувь нь экспортод гарсан байна. Үүнийг бүтээгдэхүүн болон үйлчилгээгээр задлан үзэхэд бүтээгдэхүүний нөөц буюу нийт нийлүүлсэн бүтээгдэхүүний 33.9 хувийг завсрын хэрэглээнд, 23.7 хувийг эцсийн хэрэглээнд, 16.3 хувийг хуримтлалд ашиглаж, 26.1 хувийг нь экспортлосон байна. Нийт үйлчилгээний 38.9 хувь нь завсрын хэрэглээнд, 37.8 хувь нь эцсийн хэрэглээнд, 12.0 хувь нь хуримтлалд ашиглагдсан ба 11.2 хувь нь экспортын үйлчилгээ байна.

Нийт ашигласан нөөцийн 63.8 хувийг бүтээгдэхүүн, 36.2 хувийг үйлчилгээ эзэлж байна.

Мах, махан бүтээгдэхүүний 74.5 хувийг эцсийн хэрэглээнд (хүн амын), 13.0 хувийг завсрын хэрэглээнд, 4.2 хувийг экспортод; шатахуун, цаас, цаасан бүтээгдэхүүн, химийн бүтээгдэхүүн болон бусад төмөрлөг бус бүтээгдэхүүн, цахилгаан, дулааны эрчим хүчний 73.5-98.2 хувийг завсрын хэрэглээнд, сүү, сүүн бүтээгдэхүүн, архи, дарс, пиво, ундаа, гурил, гурилан бүтээгдэхүүний 63.6-86.6 хувийг эцсийн хэрэглээнд, металл бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмжийн 53.3 хувийг завсрын хэрэглээнд, 39.0 хувь нь хуримтлалд тус тус ашиглагджээ.

Завсрын хэрэглээний 60.5 хувийг бүтээгдэхүүн, үүний дотор 13.3 хувийг шатахуун, 14.9 хувийг металл бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмж, 4.9 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч эзэлж байна.

Эцсийн хэрэглээний 52.4 хувийг бүтээгдэхүүний хэрэглээ эзэлж, үүний дотор мал, малын гаралтай түүхий эд, мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ 11.8 хувь, гурил, гурилан бүтээгдэхүүнийх 3.7 хувь, архи, дарс, пиво, ундааных 2.5 хувь байна.

Нийт хуримтлалын 70.4 хувийг бүтээгдэхүүний хуримтлал, үүний дотор 26.4 хувийг металл бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмж эзэлж байна. Хуримтлалын 29.6 хувь нь үйлчилгээний салбарт бий болжээ.

Экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээний 80.3 хувийг бүтээгдэхүүний экспорт, үүний дотор 56.3 хувийг уул уурхай, олборлох салбарын бүтээгдэхүүний экспорт, 7.9 хувийг нэхмэл, оёмол бүтээгдэхүүний, 5.2 хувийг ээрсэн утасны, 1.9 хувийг мал, малын гаралтай түүхий эд, харин үйлчилгээний экспорт 19.7 хувийг эзэлж байна.

Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс 2004 онд 11.0 хувь, 2005 онд 9.5 хувь өсч, 2006 онд өмнөх оноос 3.5 нэгжээр буурч 6.0 хувьд хүрсэн боловч 2007 онд эргээд 9.1 нэгжээр өсч 15.1 хувьд хүрлээ. Хэрэглээний үнийн индекс 2004-2007 онд дунджаар 10.4 хувь өсчээ.

Өрхийн хэрэглээний 40.0 гаруй хувийг эзэлдэг хүнсний барааны үнийн өсөлт нь үнийн ерөнхий өсөлтөд шууд нөлөөлдөг. Хүнсний барааны бүлгийн үнэ дүнгээрээ сүүлийн 4 жилд 2006 оноос бусад онуудад байнга 2 оронтой тоогоор илэрхийлэгдэж, 2004 онд 15.2 хувь, 2005 онд 15.6 хувь, 2006 онд 3.3 хувь өсч байсан бол 2007 онд хамгийн өндөр өсөлт буюу 24.6 хувьд хүрсэн байна.

Орон сууц, түлш, цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 2004-2007 онд дунджаар 7.1 хувь нэмэгдсэн бөгөөд 2004 онд 3.9 хувь, 2005 онд 4.3 хувь, 2006 онд 8.7 хувь өссөн бол 2007 онд 11.3 хувь өсчээ. Тээвэр, холбооны үйлчилгээний бүлгийн дүн 2004-2007 онд дунджаар 12.6 хувь өссөн байна.

Хэрэглээний үнийн ерөнхий индекс 2007 онд 15.1 хувь өссөний дотор хүнсний барааны үнэ бүлгийн дүнгээрээ 24.6 хувь, боловсролын үйлчилгээнийх 20.2 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 14.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 14.0 хувь, гэр ахуйн бараа, тавилгынх 13.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 11.3 хувь, тээврийнх 10.6 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 4.2 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 3.8 хувь, хувцас, гутал, бөс барааных 3.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 2.7 хувиар өсч, харин холбооны үйлчилгээнийх 10.7 хувь буурчээ.

Хэрэглээний үнийн индексийн 2007 оны 15.1 хувийн өсөлтийн 10.4 нэгж нь хүнсний барааны бүлгийн (үүнээс: талх, гурил, будааных 4.4 нэгж, мах махан бүтээгдэхүүнийх 2.8 нэгж) үнийн өсөлтөөс; 1.2 нэгж нь орон сууц, ус цахилгаан, түлшний бүлгийн; 1.1 нэгж нь боловсролын бүлгийн; 1.0 нэгж нь тээврийн бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх онуудад 7 дугаар сар хүртэл сар бүр нэмэгдэж, харин 8-аас 10 дугаар саруудад буурч байсан бол 2007 оны 8 дугаар сараас эхлэн уг хандлагад өөрчлөлт орж, үнэ оны эцэс хүртэл тасралтгүй өсөв. Үнийн сарын дундаж өсөлт оны эхний 7 сард 1.0 хувь байсан бол 8-12 дугаар сард энэ үзүүлэлт 1.5 хувь болж нэмэгджээ.

Хэрэглээний үнэ өсөхөд мах, гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ, бензин шатахууны үнэ, төмөр замын зорчигч болон ачаа тээврийн хөлс, онгоцоор зорчих хөлс, 1 квт цахилгааны үнэ, түлээ, нүүрсний үнэ, сургалтын төлбөрийн үнэ нэмэгдсэн зэрэг нь нөлөөлөв.

Түүнчлэн 2007 оны жилийн эцэст өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ бүх аймагт 14.4-28.5 хувь өссөн байна.

Мөнгө, зээл

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ өссөнөөр бизнес эрхлэгчдийн ашиг орлого нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд

Товч танилцуулга

нөлөө үзүүлж байна. Энэ байдал 2007 онд үргэлжилж үүнийг даган хадгаламж, зээлийн хэмжээ хурдацтай өсөн нэмэгдсэн нь бодит эдийн засгийг дэмжих эх үүсвэр болж байна. 2004-2007 онуудад мөнгөний нийлүүлэлт жил дараалан өсч, 2007 онд 2.4 триллион төгрөгт хүрсэн байна. Мөнгөний гол шалгуур үзүүлэлтийн нэг болох нийт мөнгө (M2)-нд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувь 2004-2007 онуудад тасралтгүй буурлаа. Энэ үзүүлэлт 2007 оны эцэст 11.8 хувь болж, 2006 онтой харьцуулахад 0.2 пунктээр буурав.

Төгрөгийн ам. доллартай харьцах 2007 оны дундаж ханш 1170.43 төгрөг байсан нь 2006 оны дундаж ханштай харьцуулахад 0.8 хувь чангарсан байна. Тайлант оны турш төгрөгийн америк доллартай харьцах ханш чангарсан нь хадгаламж эзэмшигчдийн ханшийн хүлээлтэнд өөрчлөлт оруулж, улмаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг төгрөгийн хадгаламжийн өсөлтөөр хангахад голлон нөлөөлсөн байна. Энэ нь нэг талаас сүүлийн жилүүдэд иргэдийн банкинд итгэх итгэл нэмэгдэн мөнгөн хөрөнгө банкны салбараар дамжин эдийн засгийн эргэлтэд орж, улс орны хөгжилд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байгааг илэрхийлж байна.

Банкууд дахь хадгаламжийн болон санхүүгийн зуучлалын хэмжээ өсч байгаагаас иргэд, аж ахуйн нэгжид олгох зээлийн эх үүсвэр нэмэгдэж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл өсч байна. Арилжааны банкуудын олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2007 оны эцэст 2.1 триллион төгрөг болж 2006 оныхоос 68.1 хувиар нэмэгджээ. Нийт зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2005 онд 5.8 хувь, 2006 онд 4.9 байсан бол харин 2007 онд 3.3 хувийг эзэлж байгаа нь сүүлийн жилүүдэд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь тасралтгүй буурч байгааг харуулж байна.

Зээлийн хүү харьцангуй өндөр байгаа ч аажмаар буурах хандлага ажиглагдаж байна. Банкуудын төгрөгийн зээлийн жилийн жигнэсэн дундаж хүү 2007 онд өмнөх оныхоос 4.6 пунктээр буурч 19.9 хувь, валютын зээлийн жилийн жигнэсэн дундаж хүү 1.3 пунктээр буурч 14.2 хувь болжээ.

Үнэт цаасны зах зээл. Монголын хөрөнгийн биржид 2007 оны эцсийн байдлаар 383 компани бүртгэлтэй байгаагаас 56 нь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани, 327 нь хувийн хувьцаат компани байна.

Үнэт цаасны арилжаа 2007 онд нийт 253 өдөр явагдаж, 102.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, үүнээс 40.5 тэрбум төгрөгийн бонд арилжигдсан байна. Нийт үнэт цаасны гүйлгээний үнийн дүнгийн 39.4 хувийг бондын гүйлгээ эзэлж байна. Өмнөх онуудтай харьцуулахад хөрөнгийн зах зээл дээрх үнэт цаасны арилжаа идэвхжиж, хөрөнгийн зах зээл сэргэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, хөрөнгийн зах дээрх нийт үнэлгээний дүн 716.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 5.5 дахин өссөн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд байгаагүй хамгийн өндөр түвшин юм. Мөн үнэт цаасны ханш өсч ТОП-20 индексийн зах зээлийн үнэлгээ 6699.9 болсон нь 2006 онтой харьцуулахад 5.2 дахин нэмэгдлээ. Энэ нь индексийн сагсыг бүрдүүлж буй ихэнх хувьцаат компаниудын үнэт цаасны ханш өссөнтэй холбоотой юм.

Засгийн газрын бондын арилжаа 2006 онд 2 удаа явагдсан бөгөөд арилжаанд зөвхөн банкууд оролцож байсан бол 2007 онд Засгийн газрын бондын арилжаа 10 удаа явагдаж арилжаанд банкууд болон бизнесийн бусад байгууллагууд, хувь хүмүүс оролцсон байна. Хувьцааны арилжааны хувьд 2007 онд өдөрт дунджаар 303.7 мянган хувьцаа арилжаалагдаж, 405.4 сая төгрөгийн гүйлгээ хийгджээ. 2007 онд Женко тур бюро, Монгол-Эм-Импекс, Бэрх-Уул, Туул Сонгино Усны Нөөц, Монинжбар зэрэг хувьцаат компаниудын хувьцаа тоо ширхэгээр болон үнийн дүнгээр хамгийн идэвхтэй арилжаалагдсан байна. Харин Туул Сонгино Усны Нөөц, Шарын гол, Говь, Багануур, Зоос банк зэрэг хувьцаат компаниуд зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй компанийн тоонд орж байна.

Санхүүгийн бусад салбар

Даатгал. Хүний ажил амьдралд учирч болзошгүй тааламжгүй үйл явдлын эрсдэлийг бууруулах, түүний хохирлын үр дагаврыг богино хугацаанд арилгах үр дүнтэй санхүүгийн арга хэлбэрийн нэг нь арилжааны даатгал байдаг. Манай улсын хувьд 2007 онд нийт 15 байгууллага үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэйгээр даатгалын үйл ажиллагаа, 2 байгууллага даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулсан байна. Тус даатгалын байгууллагууд нь 2007 онд 13.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олж, 3.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлжээ. Эдгээр байгууллагад давхардсан тоогоор 839.8 мянган даатгуулагч хамрагдсанаас амь даатгалд 229.0 мянга, эд хөрөнгийн даатгалд 145.1 мянга, хариуцлагын даатгалд 458.8 мянга, санхүүгийн даатгалд 6.9 мянган даатгуулагч тус тус хамрагдсан байна.

Банк бус санхүүгийн байгууллага. 2007 онд улсын хэмжээнд нийт 137 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулан 13.1 тэрбум төгрөгийн санхүүгийн орлого олж, 5.1 тэрбум төгрөгийг санхүүгийн зардалд зарцуулан, 7.3 тэрбум төгрөгийн санхүүгийн цэвэр ашигтай ажиллав. Санхүүгийн орлого 2006 оныхоос 48.8 хувь, санхүүгийн зардал 81.6 хувь, санхүүгийн цэвэр ашиг (санхүүгийн орлогоос санхүүгийн зардал болон болзошгүй эрсдлийн зардлыг хассан дүн) 32.4 хувь тус тус өссөн байна.

Хадгаламж зээлийн хоршоо. Нийт 168 нэгж тусгай зөвшөөрөлтэйгээр 2007 онд үйл ажиллагаа явуулж 8.3 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олж, 5.7 тэрбум төгрөгийг хүүгийн зарлагад зарцуулж, 2.7 тэрбум төгрөгийн хүүгийн цэвэр орлого олсон байна. Мөн тус онд 369 хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, үйл ажиллагааг нь зогсоосноор хадгаламж зээлийн хоршоодын дүнгээр хүүгийн орлого 51.4 хувиар, улмаар хүүгийн цэвэр орлого 62.5 хувиар тус тус буурсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Монгол улсын нэгдсэн төсвийн хувьд 2007 он тааламжтай жил боллоо. Татварын багц хуулийг Улсын Их Хурлаас батлан 2007 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдөж эхэллээ.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн жил бүр нэмэгдэж, 2007 оны гүйцэтгэлийг 2004 оныхтой харьцуулахад төсвийн нийт орлого 2.6 дахин өссөн бөгөөд нийт дүнгийн 99.0 хувийг урсгал орлого эзэлж байсан бол 2006 оныхтой харьцуулахад төсвийн нийт орлого 36.1 хувь өссөн бөгөөд нийт дүнгийн 99.7 хувийг урсгал орлого эзэлж байна. 2007 онд 269.2 тэрбум төгрөгийн орлогыг “Монгол улсыг хөгжүүлэх сан”-д төвлөрүүлжээ. Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн төлөвлөсөн хэмжээнээс 8.6 хувь буюу 147.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Төсвийн байгууллагын ажиллагчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2 удаа нэмэгдүүлснээс цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардал 2006 оныхоос 2007 онд 48.8 хувь, нийгмийн даатгалын сангийн зардал 47.3 хувь, халамжийн сангийн зардал 53.5 хувиар нэмэгдлээ.

Нийт зардал ба цэвэр зээлийн хэмжээ 2007 онд 1749.2 тэрбум төгрөгт хүрсэн нь 2004 оныхоос 2.3 дахин буюу 996.7 тэрбум төгрөгөөр, 2006 оныхоос 41.4 хувь буюу 512.2 тэрбум төгрөгөөр өсчээ.

Улсын нэгдсэн төсөв 2004 онд ДНБ-ний 1.8 хувьтай тэнцэх алдагдалтай байсан бол 2005 онд ДНБ-ний 2.6 хувьтай, 2006 онд ДНБ-ний 3.3 хувьтай, 2007 онд ДНБ-ний (урьдчилсан гүйцэтгэлээр) 2.2 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарлаа.

Товч танилцуулга |

Монгол Улсын төсвийн урсгал тэнцэл 1999 оноос хойш ашигтай гарсан бөгөөд 2006 онд төсвийн урсгал тэнцлийн ашиг ДНБ-ий 10.0 хувьтай тэнцэж байсан бол 2007 онд 10.6 хувь болж 0.6 пунктээр өссөн байна.

Их барилга

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2007 онд 314.3 тэрбум төгрөгт хүрсэнийг 2006 онтой харьцуулахад 17.8 хувь буюу 47.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Нийт барилга угсралт, их засварын ажлын 84.4 хувь буюу 265.2 тэрбум төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллагууд, 15.6 хувь буюу 49.1 тэрбум төгрөгийн ажлыг гадаадын болон гадаадынхантай хамтарсан барилгын байгууллагууд гүйцэтгэжээ.

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээг 2004 онтой харьцуулахад 80.4 хувь буюу 140.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2007 онд нийтдээ 228.5 тэрбум төгрөгийн орон сууц, үйлдвэр үйлчилгээний барилга объектыг ашиглалтад оруулсан нь 2006 оныхоос 62.0 хувь буюу 87.4 тэрбум төгрөгөөр өслөө.

2007 онд орон сууцны зориулалттай 3725 айлын 115 барилга, худалдаа үйлчилгээний зориулалттай 81, зочид буудлын зориулалттай 15, үйлдвэрлэлийн зориулалттай 8, нийтдээ 325 барилгыг ашиглалтад оруулсан байна.

Барилгын гол нэрийн материалын үнэ 2007 онд нилээд нэмэгдсэн бөгөөд 2006 оны эцэст нэг ширхэг улаан тоосго 80 төгрөг, нэг кг цемент 200-250 төгрөг байсан бол 2007 оны эцэст нэг ширхэг улаан тоосго 120 төгрөг, цемент нэг кг нь 300-400 төгрөг болж 50-60 хувь нэмэгдсэн нь хамгийн өндөр өсөлттэй барилгын материалууд байлаа.

Хөрөнгө оруулалт, барилга

Нийт хөрөнгө оруулалт 2007 оны урьдчилсан байдлаар 1157.1 тэрбум төгрөгт хүрч 2006 оныхоос 275.7 тэрбум төгрөг буюу 31.3 хувиар өсчээ.

Хөрөнгө оруулалтын 57.7 хувь нь дотоод эх үүсвэрийнх, 42.3 хувь нь гадаад эх үүсвэрийнх байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2007 онд 366.2 тэрбум төгрөгт хүрч 2006 оныхоос 203.5 тэрбум төгрөг буюу 2.3 дахин өслөө. Нийт хөрөнгө оруулалтын 31.6 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалт эзэлж байгаа нь 2006 оныхоос 13.2 пунктээр их байна.

2007 онд нийт хөрөнгө оруулалтын 28.7 хувийг барилга угсралт, их засварын ажилд, 58.9 хувийг машин, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулав.

Хөдөө аж ахуй

Мал аж ахуй. Манай улсын эдийн засгийн гол үндэс болсон бэлчээрийн мал аж ахуйн салбар нь эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлогод гол байр суурь эзэлсэн хэвээр байна. 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр манай улсын ДНБ-ий 20.6 хувийг хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэж, үүний 88.5 хувийг мал аж ахуйн салбар эзэлж байна. 2007 оны байдлаар улсын хэмжээгээр хөдөө аж ахуйн салбар нийт ажиллагчдын 30.0 орчим хувь, экспортын орлогын дөрөвний нэгийг бүрдүүлж байна.

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 1147.0 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 919.9 тэрбум

төгрөгт хүрч, 2006 онтой харьцуулахад оны үнээр 37.5 хувиар, зэрэгцүүлэх үнээр 17.1 хувиар өслөө.

Мал аж ахуйн салбарт 2007 онд нядалгааны жингээр 188.2 мянган тонн мах, 465.6 мянган тонн сүү, 19.2 мянган тонн ноос, 4.9 мянган тонн ноолуур, 7.2 сая ширхэг арьс шир үйлдвэрлэлээ. Өнгөрсөн онтой харьцуулахад махны үйлдвэрлэл, нядалгааны жингээр 17.4 мянган тонн, сүүний үйлдвэрлэл 15.5 мянган тонн, ноосны үйлдвэрлэл 2.4 мянган тонн, ноолуур үйлдвэрлэл 0.7 мянган тонноор, арьс шир үйлдвэрлэл 0.7 сая ширхэгээр өссөн байна.

2007 онд аминдаа малтай 226.1 мянган өрх байгаагийн 171.1 мянга нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 366.2 мянган малчид ажиллаж байна.

2007 оны мал тооллогоор нийт малчин өрхийн 60.5 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 53.1 хувь нь телевизортой, 19.7 хувь нь авто машинтай, 31.3 хувь нь мотоцикльтай, 1.5 хувь нь трактортой, 65.1 хувь нь малын хашаатай, 17.8 хувь нь худагтай байна.

Малын 2007 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр малын тоо 40.3 сая толгойд хүрч өссөний дотор тэмээний тоо 260.6 мянга, адуу 2239.5 мянга, үхэр 2425.8 мянга, хонь 16990.1 мянга, ямаа 18347.8 мянга болж дотор тэмээ 7.1 мянга, адуу 124.7 мянга, үхэр 257.9 мянга, хонь 2175.0 мянга, ямаа 2896.1 мянган толгойгоор нэмэгджээ.

Малын тоо толгойн 2007 оны өсөлт үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан байна.

Малын 2007 оны тооллогын дүнгээр бүх аймаг, Улаанбаатар хотод 2006 онтой харьцуулахад малын тоо толгой 2.9-33.0 хувиар буюу 9.3-566.9 мянган толгойгоор өссөний дотор Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Увс, Ховд, Дархан-Уул аймаг малаа таван төрөл дээр нь өсгөсөн байна.

Малын тоо, толгойн өсөлтөд 2007 онд цаг агаарын байдал тааламжтай байсан, 2006 онтой харьцуулахад малын хорогдол 182.3 мянган толгойгоор буурч, бойжуулсан төлийн тоо 1989.0 мянгаар нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөллөө.

2007 онд улсын хэмжээгээр тэжээлийн нэгжид шилжүүлснээр 513.4 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн бөгөөд хонин толгойд шилжүүлсэн нэг малд оногдуулж тооцоход 7.9 кг тэжээл ногдож байгаа нь 2006 оныхоос 1.4 кг-аар бага байна.

Хүнс хөдөө аж ахуйн яамны мэдээгээр 2007 онд сүүний чиглэлийн үнээний 494, махны чиглэлийн үхрийн 10, мах, ноосны хонины 15, гахайн 79, тахианы 111, зөгийн 40 эрчимжсэн фермерийн аж ахуй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2006 онтой харьцуулахад эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо 151-ээр нэмэгдсэн байна.

Түүнчлэн 2007 онд халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ лабораторийн оношлогоо, гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад нийт давхардсан тоогоор 52.4 сая толгой мал хамруулж, үүнд 4.5 тэрбум төгрөг зарцуулав.

Газар тариалан. Газар тариалангийн салбарын бодлого 1990 оноос өмнө үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлээр дотоодын хэрэгцээг хангахын хамт тэдгээрийг экспортлоход чиглэгдэж байсан бөгөөд жилд дунджаар 700.0-880.0 мянган тонн үр тариа, 100.0-120.0 мянган тонн төмс, 500.0-700.0 мянган тонн малын тэжээл хураан авч байсан билээ. 1990-1996 онд “Өмч эзэндээ ойртох тутам түүний үйл ажиллагаа сайжирна” гэсэн зарчимд нийцүүлэн газар тариалангийн аж ахуйнуудыг төрийн өмч оролцсон хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулсан. Улсаас шууд болон шууд бус аргаар өгөх тусламж багассан, зах зээлийн эдийн засгийн шинэ нөхцөлд аж ахуй эрхлэх менежментийн ур чадвар хангалтгүй байсан зэргээс шалтгаалан газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ нилээд буурсан үе байв.

Товч танилцуулга |

Улсын хэмжээгээр тариалсан талбай 2003 оноос жил бүр дунджаар хориод мянган га-гаар буурсан ба 2007 оны байдлаар нийт 202.7 мянган га талбайд тариалалт хийснээс 121.8 мянган га-д үр тариа, 11.5 мянган га-д төмс, 6.1 мянган га-д хүнсний ногоо, 4.9 мянган га-д тэжээлийн ургамал тариалсан нь 2006 оныхоос тариалсан талбай 40.7 мянган га-гаар буюу 25.1 хувь өссөн байна. 2007 онд 114.8 мянган тонн үр тариа, 114.5 мянган тонн төмс, 76.4 мянган тонн хүнсний ногоо, 14.1 мянган тонн тэжээлийн ургамал хурааж, 933.1 мянган тонн өвс хадлан, 35.4 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь 2006 оныхоос төмс 5.4 мянган тонноор буюу 4.9 хувь, хүнсний ногоо 6.0 мянган тонноор буюу 8.5 хувь, гар тэжээл 1.4 мянган тонноор буюу 4.1 хувь өсч, харин үр тариа 23.8 мянган тонноор буюу 17.2 хувь, бэлтгэсэн өвс хадлан 50.2 мянган тонноор буюу 5.1 хувь буурав.

Нэг га-гаас 9.4 центнер үр тариа, 99.9 центнер төмс хураасан нь 2006 оныхоос үр тариа 1.6 центнерээр, төмс 1.8 центнерээр бага байна.

Тариалангийн бүс нутгуудаар 2007 оны 7 дугаар сард агаарт 36-39 хэм хүрч 10-14 хоног үргэлжилсэн нарны хэт их халалт болсон нь таримал ургамлын ургацад муугаар нөлөөлж, улмаар хураасан үр тарианы ургацын хэмжээ, га-гаас авах ургацын хэмжээ буурахад нөлөөлсөн хэдий ч газар тариалангийн салбарт хэрэгжүүлж буй технологийн шинэчлэлийн үр өгөөж, түүнчлэн услалтын системийг сэргээн засварлаж, ашиглалтыг сайжруулсан, “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд иргэдийг хүлэмж, бага оврын усалгаатай тоног төхөөрөмж, трактораар хангах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хүн амын хүнсний гол хэрэглээ болсон төмс, хүнсний ногооны хувьд бодитой ахиц, үр дүн гарлаа.

2007 оны байдлаар манай улс улаан буудайн нийт хэрэглээний 54.4 хувь, хүнсний ногооны 72.8 хувь, төмсний 79.1 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан байна.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2007 онд оны үнээр 2563.7 тэрбум төгрөг болж, 2004 оныхоос 14.0 хувь буюу 215.7 тэрбум төгрөг, 2006 оныхоос 9.7 хувь буюу 154.6 тэрбум төгрөгөөр өсөв.

2006 онтой харьцуулахад 2007 онд мод, модон эдлэл үйлдвэрлэл, цахилгаан дулаан, уур үйлдвэрлэл, нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа, ус ариутгал, усан хангамж, нүүрс олборлолт, нэхмэлийн үйлдвэрлэл, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл, цахилгаан машин хэрэгсэл үйлдвэрлэл, резинэн болон хуванцар эдлэл үйлдвэрлэл, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, кокс, шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл, газрын тос, шатдаг хий олборлолт, төмрийн үйлдвэрлэл зэрэг салбарын үйлдвэрлэл 2.3 хувиас 2.4 дахин өсч харин металлын хүдэр олборлолт, бусад ашигт малтмал олборлолт, мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах салбарын бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт, машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл, машин тоног төхөөрөмж үйлдвэрлэл, эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл, цаг үйлдвэрлэл, арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, цаас, цаасан бүтээгдэхүүн, тамхи зэрэг салбарын үйлдвэрлэл 3.5-48.9 хувь буурлаа.

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг авч үзэхэд 2007 онд 2006 оныхоос цахилгаан, түгээсэн цэвэр ус, нүүрс, газрын тос, зэсийн болон молибдений баяжмал металл, гянтболдын баяжмал, нарийн боов, гоймон, хиамны зүйл, талх, спирт, архи, дарс, пиво, амтат ус, ундаа, цэвэр ус, жүүс, сүлжмэл эдлэл, самнасан ноолуур, угаасан ноос, эсгий, тэмээний ноосон хөнжил, ном, тарилгын эм, шахмал эм, шингэн эм,

цемент, бетон зуурмаг, бетон дэр, катодын зэс, металл бэлдэц, металл цувимал зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, харин алт, хайлуур жоншны баяжмал, өлөн гэдэс, чихэр, жигнэмэг, хүнсний давс, малын тэжээл, ээрсэн утас, төмөр замын дэр мод, сонин, шохой, барилгын хаалга, цонх, улаан тоосго, цул бетон, нэг удаагийн тариур зэрэг бүтээгдэхүүнийх буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2007 онд 2602.9 тэрбум төгрөгийн (оны үнээр) бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулав. Аж үйлдвэрийн нийт борлуулсан бүтээгдэхүүний 69.9 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэр; 22.3 хувийг боловсруулах аж үйлдвэр; 7.8 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч, ус хангамжийн салбар борлуулсан байна.

Тээвэр

Өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшдаг Монгол орны хувьд тээвэр эдийн засгийн амьдралд чухал ач холбогдолтой салбарын нэг билээ.

Сүүлийн жилүүдэд авто тээврийн байгууллагууд хувьчлагдаж хувийн хэвшил авто тээврийн салбарт зонхилох үүрэгтэй болов. Хот хоорондын болон орон нутгийн зорчигч болон ачаа тээврийн авто машин, таксины үйлчилгээ үндсэндээ бүрэн хувьчлагдав.

Хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ болон дотооддоо аж үйлдвэрийн томоохон хотууд болох Дархан, Эрдэнэт, Сүхбаатарыг холбосон 1815 километр төмөр замаар улсын нийт ачаа эргэлтийн 92.6 хувийг тээвэрлэж байна.

Бүх төрлийн тээврээр 2007 онд 23.3 сая тонн ачаа, давхардсан тоогоор 209.9 сая хүн тээвэрлэж, ачаа эргэлт 9042.0 сая тонн км, зорчигч эргэлт 3257.3 сая хүн км, нийт орлого 341.8 тэрбум төгрөгт хүрэв. Тээврийн салбарын нийт орлогын 22.3 хувь нь авто тээврээс, 50.3 хувь нь төмөр замын тээврээс, 27.4 хувь нь агаарын тээврээс оржээ.

Бүх төрлийн тээврээр 2007 онд тээсэн ачаа 2006 оныхоос 2.9 хувиар буурч, зорчигчдын тоо 7.4 хувиар өссөн байна. 2004 онтой харьцуулахад бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 7.8 хувь буюу 1689.2 мянган тонноор, зорчигчдын тоо 8.1 хувь буюу 15.7 сая хүнээр тус тус өсчээ. Төмөр замын тээврийн дамжин өнгөрөх ачаа эргэлт 2006 оныхоос 22.2 хувь буюу 1101.4 сая тонн км-ээр буурсан нь нийт ачаа эргэлтийн бууралтад нөлөөлсөн байна.

Авто техникийн 2007 оны улсын үзлэгээр бүх төрлийн авто машин нийтдээ 162.0 мянгад хүрсний 110.2 мянга нь суудлын автомашин, 33.7 мянга нь ачаа тээврийн, 13.0 мянга нь автобус, 3.8 мянга нь тусгай зориулалтын тоноглол бүхий тээврийн хэрэгсэл, 1.4 мянга нь цистерн байжээ. Нийт автомашины 57.2 хувь буюу 92.7 мянга нь Улаанбаатар хотод тоологдов. Нийт авто машины 49.5 хувь нь 10 хүртэлх жил, 50.5 хувь нь 10-аас дээш жил ашиглагджээ. Хувийн эзэмшлийн 127.0 мянган авто машин үзлэгт хамрагдсан нь нийт автомашины 78.4 хувийг эзэлж байна.

Монгол Улсын авто тээврийн сайжруулсан замын нийт урт 2007 оны эцэст 6.5 мянган км, үүнээс хатуу хучилттай зам 2.6 мянган км болжээ. 2006 онтой харьцуулбал нийт сайжруулсан замын урт 180.4 км-ээр нэмэгдэв. Үүнээс хайрган хучилттай замын урт 18.3 км-ээр, сайжруулсан хөрсөн замын урт 5.8 км-ээр тус тус буурч, хатуу хучилттай замын урт 204.4 км-ээр нэмэгджээ.

Харилцаа холбоо

Сүүлийн жилүүдэд үүрэн телефоны хэрэглэгчдийн тоо эрчимтэй өсч 2006 онд хөдөлгөөнт үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 770.1 мянга байсан бол 2007 онд 1175.1 мянгад хүрч, 2006 оныхоос 52.6 хувиар өсчээ. Харин 2004 онтой харьцуулахад хөдөлгөөнт

Товч танилцуулга

үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 2.6 дахин нэмэгдэв. Түүнчлэн сансрын хөдөлгөөнт холбооны хэрэглэгчдийн тоо 2007 онд 378-д хүрээд байна.

Суурин телефон цэгийн тоо цөөрч 1000 хүнд ногдох телефон цэгийн тоо 2006 онд 61 байсан бол 2007 онд 57 болж буурлаа.

Анхны кабелийн телевизийн сүлжээ 1996 онд байгуулагдаж байсан бол 2007 оны байдлаар улсын хэмжээнд 70 аж ахуйн нэгж, байгууллага кабелийн телевизийн үйлчилгээ явуулж, эдгээрт 89.7 мянга орчим хэрэглэгчид холбогдсон байна.

Холбооны салбарт 2007 оны 4 дүгээр сараас эхлэн үүрэн телефон холбооны дөрөвдөгч оператор үйл ажиллагаа явуулж эхэллээ.

Шуудангийн үйлчилгээний салбар 2006 онд 829.3 мянган ширхэг бичиг, захидал илгээмжийг явуулж, 17.6 сая ширхэг тогтмол хэвлэлийг хүргэж байсан бол 2007 онд 665.9 мянган ширхэг бичиг, захидал илгээмжийг явуулж 17.7 сая ширхэг тогтмол хэвлэлийг үйлчлүүлэгчдэд хүргэж 2006 оныхоос бичиг, захидал, илгээмж 19.7 хувиар буурч, тогтмол хэвлэлийн шуудан үйлчилгээ 0.6 хувиар нэмэгджээ.

Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт эргэлт 2007 онд 4 119.3 сая ам.доллар, үүнээс экспорт 1 949.2 сая, импорт 2 170.1 сая ам.доллар болсон байна. Нийт бараа эргэлт 2006 оноос 36.0 хувь, экспорт 26.3 хувь, импорт 46.7 хувиар өсөв. 2007 онд гадаад худалдааны тэнцэл 221.0 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад худалдааны алдагдал өсөхөд манай орны экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспортын хэмжээ буурсан, нөгөө талаас эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги, тээврийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүний импорт 32.0-54.8 хувиар өссөн зэрэг нь голлон нөлөөлжээ.

Экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний экспорт 2006 онтой харьцуулахад 407.4 сая ам.доллараар, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүний экспорт 1.7 сая ам. доллараар, мал амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний экспорт 1.1 сая ам доллараар нэмэгдсэн нь экспорт өсөхөд нөлөөлөв. Үнэт ба хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт 35.3 сая ам.доллараар, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 15.9 сая ам.доллараар, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэлийн экспорт 2.8 сая ам. доллараар буурлаа.

Сүүлийн жилүүдэд экспортын бүтцэд нилээд өөрчлөлт гарч байна. 2000 онд эрдэс бүтээгдэхүүний экспорт 35.2 хувь, 2004 онд 40.7 хувийг эзэлж байсан бол 2007 онд энэ үзүүлэлт 66.8 хувь болтлоо өссөн байна. Үүнд зэсийн баяжмалаас гадна цайрын баяжмалын экспорт голлон нөлөөлж байна. Харин нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин буурч байна.

Нийт экспортын үнийн дүнгийн 12.1 хувийг үнэт ба хагас үнэт чулуу, метал, гоёлын зүйлс, 13.5 хувийг нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн, 2.2 хувийг түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс эдгээрээр хийсэн эдлэл, 1.4 хувийг мал амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн эзэлж байна.

Нийт экспортод зэсийн баяжмал 41.6 хувь, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 12.1 хувь, цайрын баяжмал 9.0 хувь, самнасан ноолуур 5.9 хувь, нүүрс 6.0 хувь, бохир ноолуур 3.3 хувь, боловсруулаагүй нефть 2.8 хувь, оёмол хувцас 1.3 хувийг эзэлж, эдгээр бүтээгдэхүүний дүн нь нийт экспортын 81.8 хувийг эзэлж байна.

Нэг тонн зэсийн баяжмалын дундаж үнэ 2007 онд 1335.2 ам. долларт хүрсэн нь 2006 оныхоос 26.0 хувиар нэмэгдэв.

Үнэт, хагас үнэт чулуу, метал гоёлын зүйлсийн экспорт 2006 онд нийт экспортын дүнгийн 17.5 хувийг эзэлж байсан бол 2007 онд 12.1 хувь болж 5.4 пунктээр буурсан байна.

Хонь, хурганы боловсруулсан арьс буюу шевретийн экспортын биет хэмжээ 21.1 хувиар өсч, ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевроны экспортын биет хэмжээ 33.1 хувиар буурлаа. Түүнчлэн самнасан ноолуурын экспорт 25.0 хувиар өсч, бохир ноолуурын экспорт 9.9 хувиар багасав.

Манай улсын импорт нь хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалтын нэр төрлийг хамрахын зэрэгцээ импортын дүнд эрдэс бүтээгдэхүүний импорт өндөр хувийн жин эзэлж, түүний үнийн өсөлт нь импорт өсөхөд нөлөөллөө.

Түүнчлэн эдийн засгийн өсөлт, ялангуяа боловсруулах аж үйлдвэр, уул уурхайн салбар, худалдаа үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлттэй уялдаад импортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний импорт тайлант хугацаанд 2006 онтой харьцуулахад 152.6 сая ам.доллараар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийн импорт 153.5 сая ам.доллараар, авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт 73.3 сая ам.доллараар нэмэгдэж, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүний импорт 15.7 сая ам.доллараар буурчээ.

Эрдэс бүтээгдэхүүний импортын өсөлтөнд автобензиний импортын хэмжээ 36.5 хувь буюу 64.0 сая ам долларээр, дизель түлшний импортын хэмжээ 32.5 хувь буюу 66.4 сая ам. доллараар өссөн нь нөлөөлсөн байна.

Нийтийн тээврийн хэрэгслийн импорт 68.8 хувь буюу 5.5 сая ам долларээр, ачааны тэрэгний импорт 2.1 дахин буюу 28.9 сая ам долларээр өссөнөөс авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импортын хэмжээ нэмэгджээ.

Худалдаа, нийтийн хоол, зочид буудал

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт оны үнээр 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2 174.0 тэрбум төгрөг, нийт үйлдвэрлэлт 580.1 тэрбум төгрөг болж, нийт үйлдвэрлэлтийн хэмжээ 2004 оныхоос 205.3 тэрбум төгрөг буюу 54.8 хувь, 2006 оныхоос 125.1 тэрбум төгрөг буюу 27.5 хувиар өсөв. Худалдааны нийт үйлдвэрлэлтийн 48.9 хувийг бөөний худалдаа, 51.1 хувийг жижиглэнгийн худалдаа эзэлж байна.

2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийтийн хоолны салбарын нийт үйлдвэрлэлт оны үнээр 49.3 тэрбум төгрөгт хүрч, 2004 оныхоос 21.8 тэрбум төгрөг буюу 79.3 хувь, 2006 оныхоос 7.4 тэрбум төгрөг буюу 17.7 хувиар өсчээ. Энэ салбарт 2007 оны жилийн эцсийн байдлаар нийт 5.6 мянган хүн ажиллаж, энэ нь 2004 оныхоос 66.6 хувь буюу 2.2 мянган хүн, 2006 оныхоос 1.8 хувь буюу 99 хүнээр нэмэгдэв.

2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр зочид буудлын салбарын нийт үйлдвэрлэлт оны үнээр 39.7 тэрбум төгрөгт хүрч, 2004 оныхоос 22.8 тэрбум төгрөг буюу 2.3 дахин, 2006 оныхоос 6.6 тэрбум төгрөг буюу 19.9 хувиар нэмэгджээ. Уг салбарт 2007 оны жилийн эцсийн байдлаар нийт 4.9 мянган хүн ажиллаж, энэ нь 2004 оныхоос 2.0 дахин буюу 2.4 мянган хүн, 2006 оныхоос 18.5 хувь буюу 757 хүнээр илүү байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр 68.8 сая ам.долларын ашигтай гарч, ашгийн хэмжээ 2006 оныхоос 68.4 хувь буюу 149.2 сая ам.доллараар буурсан байна. Урсгал дансны ашиг буурахад бараа болон үйлчилгээний

Товч танилцуулга

тэнцэл алдагдалтай гарсан явдал голлон нөлөөлсөн байна. Барааны тэнцэл 2007 онд 24.5 сая ам.долларын, үйлчилгээний тэнцэл 39.9 сая ам.долларын алдагдалтай гарав. Бараа, үйлчилгээний тэнцэл алдагдалтай гарахад барааны импортын өсөлт экспортын өсөлтөөс илүү хурдацтай байсан, түүнчлэн тээврийн болон даатгалын үйлчилгээний зардал өссөн, барилга угсралтын ажил эрчимжсэн нь нөлөөлжээ.

Хөрөнгө ба санхүүгийн данс 171.9 сая ам.долларын ашигтай гарч 2006 оноос 47.8 хувиар буюу 55.6 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Тайлант жилд 324.1 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэн нь 2006 оныхоос 34.5 сая ам.доллараар өсчээ.

Нийт төлбөрийн тэнцэл 288.0 сая ам.долларын ашигтай гарч 2006 онтой харьцуулахад 101.3 сая ам.доллараар буурсан байна.

Орон сууц, нийтийн аж ахуй

Улсын хэмжээгээр 2007 онд нийт 446.6 мянган ам метр талбай бүхий орон сууцыг ашиглалтад оруулснаар орон сууцны фонд 8105.1 мянган ам метр болж, 2004 оныхоос 13.7 хувь, 2005 оныхоос 10.0 хувь, 2006 оныхоос 4.7 хувь тус тус өсчээ.

Ус түгээх цэгийн тоо 2006 онд 1164 болж, 2006 оноос 9.0 хувь өслөө. Зөөврийн ус хэрэглэдэг өрхийн тоо 2007 онд 313.7 мянгад хүрч өмнөх оныхоос 5.9 хувь буюу 17.5 мянгаар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2006 онд халуун усны нийт 393 цэг ажиллаж байсан бол 2007 онд энэ үзүүлэлт 458 болж 16.5 хувь өсчээ.

Нийт 878 зочид буудал 2007 онд ажиллаж байсан нь 2006 онтой харьцуулахад 10.6 хувь буюу 84-өөр нэмэгдсэн байна.

Аялал жуулчлал

Монгол Улсын хилээр 2007 онд давхардсан тоогоор 2.9 сая зорчигчид нэвтэрсэн нь 2006 оныхоос 20.7 хувиар буюу 491.6 мянган хүнээр нэмэгдсэн байна. Улсын хилээр 2007 онд орсон нийт зорчигчдын 53.0 хувь нь Замын Үүд боомтоор; 16.3 хувь нь Буянт Ухаа боомтоор; 9.0 хувь нь Алтанбулаг боомтоор; 2.3 хувь нь Шивээхүрэн боомтоор; 19.4 хувь нь бусад боомтуудаар орж иржээ.

Монгол Улсад 2007 онд гадаадын 454.8 мянган зорчигчид орж ирсэн нь 2006 оныхоос 11.3 хувь буюу 46.3 мянган хүнээр нэмэгджээ. Тэдгээрийн 95.6 хувь нь 30 хүртэл хоног; 2.9 хувь нь 90 хүртэл хоног; 1.5 хувь нь 90 ба түүнээс дээш хоног байхаар ирсэн бөгөөд 62.8 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгаас; 32.8 хувь нь Европоос; 3.3 хувь нь Америк тивээс; 0.3 хувь нь Ойрхи Дорнодоос; 0.8 хувь нь Өмнөд Ази, Африк тивээс ирсэн байна.

Манай улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 46.7 хувийг БНХАУ-ын иргэд; 21.9 хувийг ОХУ-ын иргэд; 9.7 хувийг БНСУ-ын иргэд; 3.8 хувийг Япон улсын иргэд; 2.7 хувийг АНУ-ын иргэд; 15.2 хувийг бусад орны иргэд эзэлж байна.

Монгол Улсад 2007 онд 451.8 мянган жуулчид орж ирсэн нь 2006 оныхоос 17.0 хувь буюу 65.8 мянган хүнээр нэмэгдсэн байна. 2007 онд орж ирсэн жуулчдын 63.0 хувь нь Зүүн Ази; Номхон далайн бүс нутгаас; 31.6 хувь нь Европоос; 3.5 хувь нь Америк тивээс; 1.9 хувь нь Ойрхи Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Манай улсын хилээр 2007 онд гарсан 990.6 мянган дотоодын зорчигчдын 89.2 хувь нь хувийн журмаар, тэдгээрийн дийлэнх буюу 93.1 хувь нь БНХАУ, ОХУ, БНСУ руу зорчжээ.

Гадаадад 2007 онд зорчсон монгол иргэдийн ихэнх нь 30 хүртэл хоногийн хугацаатай явсан бол гадаадын иргэдийн дийлэнх нь мөн ийм хугацаагаар манай улсад орж иржээ.

Аялал жуулчлалын салбарт 2007 оны эцсийн байдлаар үйл ажиллагаа явуулсан 403 аж ахуйн нэгж, байгууллага бизнес регистрийн санд бүртгэгдсэн нь 2006 оныхоос 15-аар буюу 3.6 хувиар цөөрчээ.

Уг салбарт 2007 оны жилийн эцсийн байдлаар 1.9 мянган хүн ажиллаж байсан нь 2006 оны жилийн эцсийнхээс 3.8 хувь буюу 68 хүнээр нэмэгдсэн байна.

Өрхийн орлого, зарлага, хүн амын амьжиргааны түвшин

Өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгааны дүнгээс харахад 2007 онд нэг өрхийн сарын дундаж нийт орлого 2006 онтой харьцуулахад оны үнээр 31.7 хувь өсөв. Үүнээс цалин хөлсний дундаж орлого улсын хэмжээгээр 2007 онд 2006 оныхоос 38.7 хувь, 2005 оныхоос 57.6 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого дунджаар 2006 оныхоос 76.2 хувь, 2005 оныхоос 2.3 дахин тус тус нэмэгдсэн байна. Харин инфляциар засварласан бодит өсөлтөөр цалин хөлсний орлого 2007 онд 2006 оныхоос 20.5 хувь, 2005 оныхоос 36.9 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 2006 оныхоос 53.1 хувь, 2005 оныхоос бараг 2 дахин өссөн дүнтэй гарлаа. Өрхийн мөнгөн орлого 2007 онд, 2004 онтой харьцуулахад 65.9 хувь, үүнээс цалингийнх 92.2 хувь, тэтгэвэр, тэтгэмжийнх 2.6 дахин, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнийх 24.3 хувь, бусад орлого 35.6 хувь нэмэгдэв.

Тэтгэвэр, тэтгэмжийн орлого болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн орлого 2007 онд 2006 оныхоос 76.2-90.0 хувь өссөн нь өөрийн хувийн аж ахуйгаас бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүний нийт орлогод эзлэх хувийн жин мөн хугацаанд 5.0 пунктээр буурахад нөлөөлсөн байна.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага оны үнээр 2007 онд 2006 оныхоос 33.0 хувь, үүний дотор хүнсний зүйлийн мөнгөн зарлагынх 33.5 хувь, 2005 оныхоос 55.9 хувь, хүнсний бус бараа үйлчилгээнийх 2006 оныхоос 34.8 хувь, 2005 оныхоос 57.8 хувиар өсчээ. Өрхийн зарлагын бүтцийг харвал 2004-2007 онд өрхийн нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 77.1-ээс 91.6 хувь болсон нь өрхийн хэрэглээнд өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн хэмжээ буурсантай холбоотой байна.

Ядуурлын үндсэн үзүүлэлтийг өрхийн орлого, зарлагын 2006 оны судалгааны дүнгээр тооцож үзэхэд 2002-2003 оныхоос улсын дунджаар ядуурлын хамралт 3.9 пункт, ядуурлын гүнзгийрэлт 0.9 пункт, ядуурлын мэдрэмж 0.2 пунктээр бага байгаа нь ядуурлыг бууруулахад нааштай хандлага гарч байгааг харуулж байна.

Боловсрол

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнгээс үзэхэд Монгол Улсын 15 ба түүнээс дээш настай хүн амын 97.6 хувь нь бичиг үсэгт тайлагдсан байв.

Бүх шатны сургуульд суралцагсдын тоо (Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчдийн тоог оруулахгүйгээр) 2007-2008 оны хичээлийн жилийн эхэнд 733.2 мянгад хүрч 2004 оныхоос 3.2 хувиар нэмэгджээ.

ЕБС-д 2007-2008 оны хичээлийн жилд суралцагчдын тоо (орой, эчнээгээр суралцагчид ороогүй) 537.5 мянгад хүрсэн байна.

Товч танилцуулга |

Орой, эчнээ ангид суралцаж байгаа суралцагчдын тоо 2007-2008 оны хичээлийн жилд 3.9 мянга болсон нь 2004-2005 оны хичээлийн жилээс 8.2 мянгаар буюу 67.8 хувиар буурчээ. Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа оюутны тоо тогтмол өсч байгаа бөгөөд 2007-2008 оны хичээлийн жилд нийт 180.2 мянган оюутан суралцаж байна. Энэ хичээлийн жилд суралцаж байгаа нийт оюутны 69.9 хувь нь төрийн өмчийн, 30.1 хувь нь хувийн хэвшлийн сургуульд суралцаж байна.

Бүх шатны сургалтын байгууллагыг төгсөгчдийн тоо өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2006-2007 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн тоо 132.8 мянга болж, 2005-2006 оны хичээлийн жилийнхээс 1.7 мянгаар, 2004-2005 оны хичээлийн жилийнхээс 4.7 мянгаар нэмэгджээ.

Сургуулиас завсардсан 7-15 насны хүүхдийн тоо 2007-2008 оны хичээлийн жилд 8.8 мянга болжээ. Сургууль завсардалтын хувь 2007-2008 онд 1.6 хувь болж, 2006-2007 оныхоос 0.6 пунктээр буурсан байна.

2007-2008 оны хичээлийн жилд 60.0 мянган хүүхэд нэгдүгээр ангид шинээр элссэн нь 2006-2007 оны хичээлийн жилийнхээс 7.0 хувиар нэмэгдэв. Энэ нь ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн тогтолцоонд шилжүүлснээр 7 настай хүүхэд ЕБС-д элсэн орох болсонтой холбоотой.

ЕБС-ийн нэг багшид ногдох хүүхдийн тоо 2007-2008 онд 22.5 болж 2006-2007 оны хичээлийн жилийнхээс 1.2 пунктээр буурлаа. ЕБС-ийн багш нарын тоо жилээс жилд өсч байгаа бөгөөд 2007-2008 онд 4.4 хувь буюу 1.0 мянгаар нэмэгдэж, 23.8 мянга болов.

Дотоодын их, дээд сургуулийн төгсөгчдийн тоо нэмэгдэж байгаа ба 2006-2007 онд нийт 25.9 мянган оюутан төгссөнөөс 28.7 хувь нь худалдаа, бизнесийн удирдлага, 12.6 хувь нь багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх, 10.6 хувь нь инженерийн, 6.2 хувь нь хууль, эрх зүй мэргэжлээр төгссөн байна.

Сургуулийн өмнөх байгууллагад 2007-2008 оны хичээлийн жилийн байдлаар 105.5 мянган хүүхэд хамрагдаж байгаа нь 2006-2007 оныхоос 6.5 хувиар, 2004-2005 оноос 22.5 хувиар нэмэгдэв.

Шинжлэх ухаан, соёл урлаг

Шинжлэх ухааны байгууллагад ажиллагчдын тоо 2007 онд 3.5 мянга болж, 2006 оныхоос 2.1 хувь өсчээ. Нийт ажиллагчдын 68.8 хувь нь үндсэн ажиллагчид байна. Шинжлэх ухааны нэг байгууллагад ногдох ажиллагчдын дундаж тоо 2004 онд 58 байснаа 2005 онд 56, 2006 онд 57, 2007 онд 59 болж өсөв.

Шинжлэх ухааны салбарын нийт зардал 2007 онд 10.1 тэрбум төгрөг болж, 2006 оныхоос 31.4 хувиар өсөв.

Шинжлэх ухааны байгууллагуудын салбарын зардлын бүтцийг авч үзвэл 2007 онд нийт зардлын 17.9 хувь нь техникийн салбарт, 29.6 хувь нь байгалийн, 10.8 хувь нь хөдөө аж ахуйн, 6.9 хувь нь анагаах ухааны, 15.0 хувь нь нийгмийн ухааны салбарт, 19.8 хувь нь их, дээд сургуульд ногдож байна.

Улсын төсвөөс санхүүжигдсэн эрдэм шинжилгээний ажлын тоо 2007 онд 374 болж, 2006 оныхоос 9.0 хувь, үүний дотор онолын суурь судалгааны тоо 15.8 хувь, шинжлэх ухаан, технологийн зэхэц ажлын тоо 5.1 хувь, шинжлэх ухаан, технологийн төслийн тоо 0.8 хувиар өсчээ.

Улсын төсвөөс санхүүжигдсэн эрдэм шинжилгээний ажлын зардал 2007 онд 7030.0 сая төгрөг болж, 2006 оныхоос 24.1 хувь нэмэгдэв. Үүнээс шинжлэх ухаан, технологийн зэхэц ажилд 3.7 хувь, шинжлэх ухаан, технологийн төсөлд 47.2 хувь, онолын суурь судалгаанд 49.1 хувийг зарцуулсан байна.

Улсын хэмжээнд ажиллаж байгаа нийтийн номын сан, уншигчдын тоо өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2004 онд нийт 278 нийтийн номын сан ажиллаж, 223.3

мянган байнгын уншигч үйлчлүүлж байсан бол 2007 онд 342 номын сангаар 336.5 мянган уншигч үйлчлүүлжээ.

Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын тоо 2007 онд 3.5 мянга болж, 2006 оныхоос 28.6 хувиар буурч, үзэгчдийн тоо 1508.7 мянга болж 2006 оныхоос 18.0 хувиар өссөн байна.

Музейн үзмэрийн тоо 2007 онд 216.9 мянга болж, 2006 оныхоос 4.3 хувь; үзэгчдийн тоо 453.0 мянга болж, 9.9 хувиар нэмэгдлээ.

Сүм хийд

Монгол Улсын /1992 оны/ шинэ үндсэн хуулиар иргэдийн шүтэх, эс шүтэх эрх нь чөлөөтэй болсноор янз бүрийн урсгалын сүм хийдүүд байгуулагдаж эхэлсэн. Юуны түрүүнд уламжлалт буддын шашны сүм хийд олноор байгуулагдаж эхэлсэний зэрэгцээ христийн болон шашны бусад урсгалын сүм хийд, шашны байгууллагуудын тоо нэмэгдэж байна. Хөдөө орон нутагт уламжлалт шашны (будда, ислам), төв суурин газруудад бусад шашны сүм хийд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Сүм хийдийг шашны төрлөөр нь авч үзвэл 2007 оны байдлаар нийт 249 сүм хийд байгаа бөгөөд 2004 онтой харьцуулахад 10.7 хувь, 2005 онтой харьцуулахад 3.8 хувь, 2006 онтой харьцуулахад 1.6 хувь өсөв. 2007 онд нийт сүм хийдийн 55.4 хувийг будда, 35.7 хувийг христ, 8.0 хувийг ислам, 0.8 хувийг бусад шашны сүм хийд эзэлж байна.

Сүм хийд шашны байгууллагуудад 2007 оны байдлаар нийт 4.0 мянган хүн ажиллаж байгаагаас хурлын лам 1.5 мянга байна. Хурлын лам нарыг бүсээр авч үзвэл Баруун бүсэд 149 буюу 10.1 хувь, Хангайн бүсэд 472 буюу 31.9 хувь, Төвийн бүсэд 267 буюу 18.0 хувь, Зүүн бүсэд 132 буюу 8.9 хувь Улаанбаатарт 461 буюу 31.1 хувь нь тус тус ногдож байна. Шашны сургууль дацанд суралцагсад 2007 онд 2.2 мянга болж 2006 оныхоос 35.2 хувь буурсан бол гэрээр ном заалгадаг хүүхдийн тоо 5.4 мянга болж 47.6 хувиар өссөн байна.

Хүн амын эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагуудад 2007 оны байдлаар нийт 35.2 мянган ажиллагчид байгаагийн 7.3 мянга нь их эмч, 8.6 мянга нь сувилагч, 844 нь эм зүйч, 15.1 мянга нь эмнэлгийн дунд мэргэжилтэн, 11.9 мянга нь бусад мэргэжлийн эмч, мэргэжилтэн нар байна. Эмнэлгийн удирдах ажилтан, мэс заслын ба гэмтэл, согог заслын, эх барих, эмэгтэйчүүдийн, хавдар судлаач, нүдний, чих, хамар, хоолойн, дүрс оношлогоо, дурангийн, мэдрэлийн, шүд, эрүү, нүүрний, эмгэг судлаач, шүүхийн шинжээч, уламжлалт эмчилгээний эмч нарын тоо 2006 онтой харьцуулахад өсч, харин дотрын, хүүхдийн, БЗДХ, гоц халдвартын, арьс харшлын, нөхөн сэргээх эмчилгээний, мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний, өрхийн, лабораторийн, эрүүл ахуйч эмч нарын тоо буурчээ.

Харин 2007 онд эмнэлгийн дунд мэргэжилтний тоо 2004 оныхоос 5.2 хувь, 2005 оныхоос 4.8 хувь, 2006 оныхоос 1.7 хувиар их байна. Нэг их эмчид 1.2 сувилагч, нэг их эмчид 353 хүн, нэг сувилагчид 300 хүн ногдож байна. Их эмчийн тоо 2007 онд 2004 оныхоос 11.3 хувь, 2005 оныхоос 8.1 хувь, 2006 оныхоос 3.6 хувь нэмэгдэв. Эмнэлгийн орны тоо 2007 онд 18.0 мянга болж 2004 оныхоос 2.0 хувь, 2005 оныхоос 1.5 хувь, 2006 оныхоос 1.9 хувиар буурч, улсын дундаж ор хоног 8.7 байгаа нь 2004 оныхоос 1 пункт, 2005 оныхоос 0.8 пункт, 2006 оныхоос 0.3 пунктээр тус тус буурсан байна.

10 000 хүн амд ногдох эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлөөс шээс бэлгэсийн тогтолцооны (340.9), жирэмслэх, төрөх, төрсний дараах үе (334.1), амьсгалын тогтолцооны (328.3), хоол шингээх эрхтний өвчин (349.2) болон цусны эргэлтийн тогтолцооны (318.5)

Товч танилцуулга

өвчин зонхилж байгаа бөгөөд харин хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин (10 000 хүн амд 21.9), хавдар (10 000 хүн амд 12.2), осол гэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл (10 000 хүн амд 11.7), хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин (10 000 хүн амд 5.5), амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин (10 000 хүн амд 2.3) орж байна. Хорт хавдрын өвчлөлөөс элэг (10 000 хүн амд 4.9), умайн хүзүү (10 000 хүн амд 0.4), ходоод (10 000 хүн амд 1.8), уушги (10 000 хүн амд 1.1), улаан хоолойн (10 000 хүн амд 1.0) хорт хавдар тэргүүлж байна.

2007 онд улсын хэмжээнд 29 төрлийн цочмог халдварт өвчин бүртгэгдэж, халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 41.1 мянгад хүрч, 2004 оны дунджаас 31.2 хувь, 2005 оныхоос 27.1 хувь, 2006 оныхоос 13.4 хувиар нэмэгдэж, сүүлийн үед жил дараалан өсөх хандлага хэвээрээ байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 24.4 хувийг вируст гепатитаар, 11.1 хувийг гонококкт халдвараар, 10.6 хувийг сүрьеэгээр, 10.6 хувийг трихомониазаар, 8.0 хувийг тэмбүүгээр, 5.8 хувийг цусан суулгаар, 4.9 хувийг салхин цэцгээр өвчлөгчид эзэлж байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо нэмэгдэж байгаагийн гол шалтгаан нь хүн амын дунд улаанууд, салхин цэцэг, вируст гепатит, цусан суулга өвчин дэгдэлт, ялангуяа цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийн дунд илүү эрчтэй тархсантай холбоотой. 2007 онд нийт вируст гепатитаар өвчлөгчдийн 89.0 хувь нь А хэлбэрийн вируст гепатитаар өвчилсөн нь нийгмийн эрүүл ахуй, ариун цэвэр муу байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

“Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд цусны даралт ихсэх, чихрийн шижин, умайн хүзүүний болон хөхний хавдар, сүрьеэ өвчнийг илрүүлэх зорилгоор Баян-Өлгий аймагт 5206, Дундговь аймагт 2502, Сүхбаатар аймагт 3112, Увс аймагт 5408, Улаанбаатар хотод 3964, нийт 20192 хүн үзлэгт хамруулснаас Баян-Өлгий аймагт 2488, Дундговь аймагт 409, Сүхбаатар аймагт 1647, Увс аймагт 2162, Улаанбаатар хотод 169, нийт 6875 хүнд дээрх өвчний сэжигтэй тохиолдлыг илрүүлсэн байна.

Эрүүл мэндийн салбарын нийт зардал 2007 оны урьдчилсан гүйцэтгэл 144.4 сая төгрөг болж, 2004 оныхоос 2 дахин, 2005 оныхоос 1.8 дахин, 2006 оноос 40.0 хувиар өсөв. Улсын нэгдсэн төсвийн зарлагад эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2007 онд 7.3 хувь болж, 2004 оныхоос 2.4 пунктээр, 2005 оныхоос 3.2 пунктээр, 2006 оныхоос 1.1 пунктээр тус тус буурав.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн халамжийн сангийн орлого 2007 онд 117.8 тэрбум төгрөгт хүрч 2006 оныхоос 57.3 хувиар өсөв.

Нийгмийн халамжийн зардал 2007 онд 115.3 тэрбум төгрөгт хүрч 2006 оныхоос 52.3 хувь буюу 39.9 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ. 2006 онтой харьцуулахад нийгмийн халамжийн зардалд тэтгэврийн эзлэх хувь буурч, харин тэтгэмжийн эзлэх хувь өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмж, тусламж авсан хүний тоо 2007 онд 1176.6 мянгад хүрч 2006 оныхоос 12.3 хувиар нэмэгдэв.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийн хүрээнд 2007 онд нийт 948.7 мянган хүүхдэд 33.2 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон нь 2006 оныхоос хүүхдийн тоо 8.7 хувь буюу 76.3 мянгаар, олгосон тэтгэмжийн хэмжээ 26.6 хувь буюу 6.9 тэрбум төгрөгөөр их байна.

Шинээр мэндэлсэн хүүхэд бүрт төрөөс 100.0 мянган төгрөгийн тэтгэмжийг жилд нэг удаа олгож байна. Энэ арга хэмжээнд 57.7 мянган хүүхдэд 5.8 тэрбум төгрөгийг зарцуулсан нь 2006 оныхоос хүүхдийн тоо 40.3 хувь буюу 16.6 мянгаар нэмэгдлээ. Анх удаа гэрлэгчдэд олгох 500.0 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг 59.4 мянган гэрлэсэн хосод олгож, нийт 29.7 тэрбум төгрөгийг зарцуулав.

Түүнчлэн “Үдийн цай” хөтөлбөрт 2007-2008 оны хичээлийн жилд 185.9 мянган сурагчдыг хамруулж, улсын төсвөөс 9.3 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо 2007 онд 292.6 мянган хүн болж 2006 оныхоос 0.7 хувь буюу 2.1 мянгаар нэмэгдлээ. 2007 онд олгосон нийт тэтгэврийн 72.4 хувийг өндөр насны, 12.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 9.1 хувийг тэжээгчээ алдсаны, 5.6 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна. Нийт тэтгэвэр авагчдын дотор өндөр насны тэтгэвэр авагчдын эзлэх хувь өсч, харин тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын эзлэх хувь буурах хандлагатай байна. Тухайлбал, нийт тэтгэвэр авагчдын дүнд өндөр насны тэтгэвэр авагчдын эзлэх хувь 2004 онд 69.1 хувь байснаа 2007 онд 72.4 хувь болж нэмэгдэж, харин тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын эзлэх хувь 2004 онд 11.4 хувь байснаа 2007 онд 9.1 хувь болж буурчээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2007 онд 326.6 тэрбум төгрөгт хүрч 2004 оныхоос 2.1 дахин нэмэгдэв.

“Хүүхэд хөгжил” судалгаа

Судалгааны дүнгээс үзэхэд сүүлийн таван жилд тав хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн байдал мэдэгдэхүйц сайжирсан байна. Тураалтай хүүхдийн эзлэх хувь 2005 онд 2000 оныхтой харьцуулахад хоёр дахин буурав. Таван жилийн өмнө тав хүртэлх насны найман хүүхдийн нэг нь (12.7 хувь) тураалтай байсан бол одоо арван зургаан хүүхдийн нэг нь (6.3 хувь) тураалтай байна. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд тав хүртэлх насны хүүхдүүдийн дунд өсөлтийн хоцролттой хүүхдийн хувь 25 байснаа 21 хувь болов. Сүүлийн таван жилд тав хүртэлх насны хүүхдүүдийн дунд туранхай хүүхдийн эзлэх хувь 5.5 хувь байснаа 2.2 хувь болж буурсан дүн гарлаа.

Нийт 6-59 сартай хүүхдүүдийн дунд “А” аминдэм уусан хүүхдийн эзлэх хувь 2000 онд 32 хувь байснаа 2005 онд 65 хувь болж, хоёр дахин өсөв. 2000 оны судалгаанаас үзэхэд эхчүүдийн 13 хувь нь хүүхдээ төрүүлснээс хойшхи 8 долоо хоногийн хугацаанд өндөр тунт “А” аминдэм хэрэглэж байсан бол 2005 онд энэ үзүүлэлт 56 хувь болжээ.

2000 оны байдлаар нийт өрхийн 45 хувь нь иоджуулсан давс хэрэглэж байсан бол 2005 онд 83 хувь болж өссөн байна. Иоджуулсан давсны хэрэглээг өрхийн байршлаар авч үзвэл нийслэл УБ хотын өрхийн 96.8 хувь нь хүнсэндээ иоджуулсан давс хэрэглэж байхад энэ үзүүлэлт хөдөөд 69.8 хувь байна.

Сүүлчийн судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 88 хувь нь ДОХ-ын талаар сонсож, 56 хувь нь ХДХВ бэлгийн замаар халдварлахаас сэргийлэх үндсэн 3 аргыг мэддэг гэж хариулт өгчээ. ХДХВ халдварлахаас сэргийлэх 2 арга замыг мэддэг эмэгтэйчүүдийн хувь 66, ХДХВ-ийн талаарх 3 ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан эмэгтэйчүүдийн хувь 38, харин энэ үзүүлэлтийг нэгтгэж гаргасан ХДХВ/ДОХ-ын талаар цогц мэдлэгтэй эмэгтэйчүүдийн хувь 31 байна.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 79 хувь нь ХДХВ эхээс хүүхдэд халдварладаг болохыг мэддэг мөн 57 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээг хаана хийлгэхийг мэддэг бөгөөд 15 хувь нь шинжилгээнд хамрагджээ. Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 62 хувь нь жирэмсний хяналтын үед ХДХВ/ДОХ-оос сэргийлэх талаар мэдээлэл авсан бөгөөд 37 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн байна.

Гэмт хэрэг

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2007 онд 21.3 мянга болж, 2006 оныхоос 16.5 хувь өслөө. Гэмт хэргийн гаралтыг бүс нутгаар авч үзвэл энэ оны нийт

Товч танилцуулга

бүртгэгдсэн гэмт хэргийн 8.5 хувь нь Баруун бүсэд, 13.0 хувь нь Хангайн бүсэд, 18.0 хувь нь Төвийн бүсэд, 9.4 хувь нь Зүүн бүсэд, 49.4 хувь нь Улаанбаатарт ногдож байгаа бөгөөд төрлөөр нь авч үзвэл хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 27.5 хувийг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 51.1 хувийг, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8.4 хувийг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 6.3 хувийг, бусад гэмт хэрэг 6.7 хувийг эзэлж байна. Хүчингийн хэргийн тоо 355 болж, 2006 оныхоос 13.1 хувиар өсч, бусдыг болгоомжгүй алсан гэмт хэргийн тоо 2007 онд 14 болж, 2006 оныхоос 6.7 хувиар буурав.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн тоо 2007 онд 5.8 мянга болж 2006 оныхоос 10.7 хувь өсчээ. Иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн тоо 2007 онд нэмэгдсэн гол шалтгаан нь согтуугаар хүний биед хүнд болон хөнгөн гэмтэл учруулах явдал түгээмэл байгаатай холбоотой юм. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2007 онд 4.8 мянгад хүрч, 2006 оныхоос 29.1 хувь өссөн байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт зам тээврийн осол болон тээврийн осол гарсан газрыг санаатай орхих гэмт хэрэг багтдаг бөгөөд тухайн гэмт хэргийн тоо 219 буюу 9.1 хувь буурчээ.

Малын хулгайн гэмт хэрэг 2007 онд (1.9 мянга) 2006 оныхоос 13.7 хувиар багасав.

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн тоо 2007 онд (384) 2006 оныхоос 12.0 хувь өслөө. Энэ төрлийн хэргийн 92.4 хувийг хүчингийн хэрэг эзэлж байгаа нь 2006 оныхоос 0.9 пунктээр нэмэгдсэн. Хүчингийн хэргийн 45.9 хувь нь Улаанбаатарт гарсан байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 73.0 хувийг хулгай, 7.5 хувийг залилан, 6.0 хувийг дээрэм, 6.5 хувийг булаалт, 3.3 хувийг бусдын хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэрэг эзэлж байна.

Харин нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 97.0 хувийг танхайн гэмт хэрэг эзэлж, 2006 онтой харьцуулахад Баянхонгор, Төв, Архангай, Дархан, Говьсүмбэр, Улаанбаатар, Дорнод, Говь-Алтай, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд аймаг, нийслэлд 3.4-42.9 хувь, Баян-Өлгий, Сүхбаатар аймагт 2.1- 2.7 дахин нэмэгджээ.

Шүүхээр 2007 онд 8.5 мянга хүн шийтгүүлсэний 8.4 хувь нь эмэгтэйчүүд, 11.4 хувь нь хүүхдүүд байгаа бөгөөд ял шийтгүүлсэн хүүхдүүдийн 4.8 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Гэмт хэргийн улмаас 2007 онд 1.6 мянган хүн нас барсны 74.2 хувь буюу 1.2 мянга нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас, 21.5 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн, 4.3 хувь нь бусад гэмт хэргийн улмаас нас баржээ.

Гэмт хэргийн улмаас 2007 онд нийт 29.5 тэрбум төгрөгийн хохирол учирсны 53.6 хувь буюу 15.8 тэрбум төгрөг нь иргэдийн өмчид учирсан хохирол байна. Үүнээс: Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны улмаас 400 сая төгрөг, мал хулгайлах гэмт хэргийн улмаас 3.1 тэрбум төгрөгийн хохирол иргэдэд учирсан байна. Нийт хохирлын 13.6 хувийг нөхөн төлүүлжээ.

Байгаль орчин

Сүүлийн жилүүдэд Монгол оронд ган, зуд, хүчтэй цасан болон шороон шуурга, үер, түймэр, хөнөөлт шавьж, мэрэгч зэрэг байгалийн гамшигт үзэгдэл олонтаа тохиолдож, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ихээхэн хохирол учруулж байна. Түүнчлэн хүн амын төвлөрөл ихсэх, байгальд учруулж буй дарамт нэмэгдэх, уур амьсгал хуурайших зэрэг шалтгаанаас цөлжилт эрчимжих хандлага ажиглагдаж байна.

2007 оны байдлаар нийт газар нутгийн 74.8 хувийг хөдөө аж ахуйн газар, 15.8 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 9.1 хувийг ойн сан бүхий газар, 0.4 хувийг усны

сан бүхий газар, 0.3 хувийг хот, тосгон, бусад суурины газар, 0.2 хувийг зам, шугам, сүлжээний газар эзэлж байна.

Ойн түймэр 2004 онд 46 удаа, 2005 онд 47 удаа, 2006 онд 90 удаа гарч байсан бол 2007 онд 216 болж өсчээ. Бүсээр авч үзвэл түймэр гарсны 18 нь баруун бүсэд, 50 нь хангайн бүсэд, 60 нь төвийн бүсэд, 41 нь зүүн бүсэд, 47 нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээр гарлаа.

Байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 2007 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4591.5 сая төгрөгт хүрч, 2004 оныхоос 2.0 дахин, 2006 оныхоос 75.3 хувиар нэмэгдсэн бөгөөд үүнээс 20.5 хувийг нь байгаль орчны төвлөрсөн арга хэмжээнд, 23.4 хувийг нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтад, 18.8 хувийг нь ойжуулах ажиллагаанд, 22.9 хувийг нь байгаль орчны алба, байгаль хамгаалагчдын үйл ажиллагаанд, 14.4 хувийг нь байгаль хамгаалах санд зарцуулжээ.

Газарт учруулсан хохирлыг авч үзвэл 2004 онд 13 082.2 мянган га, 2005 онд 11482.6 мянган га, 2006 онд 11 078.9 мянган га-д хохирол учирч байсан бол 2007 онд нийт 14 076.6 мянган га газарт хохирол учирсны 350.1 мянган га нь тариалангийн газрын, 12305.4 мянган га нь бэлчээр ба бусад өвслөг газрын, 17.4 мянган га нь хот суурин газрын, 1356.9 мянган га нь ойн сан бүхий газрын, 3.6 мянган га нь усны сан бүхий газрын, 43.2 мянган га нь ухагдаж эвдэрсэн газар байна.

Аюулт үзэгдэл, осол гамшиг 2007 онд нийт 3072 удаа гарлаа. Үүний улмаас 200.6 тэрбум төгрөгийн хохирол учирч, 219 хүн амь насаа алдаж, 1431 гэр, орон сууц, 1335.2 мянган га газар шатаж, 10.8 мянган мал хорогдсон байна.

Бүтээмж

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд нэгж зардлаар хэдий хэр бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж байгааг тодорхойлдог үзүүлэлт юм.

Бүтээмжийг дотор нь нийт бүтээмж, үндсэн хүчин зүйлийн бүтээмж, тодорхой хүчин зүйлийн бүтээмж гэсэн 3 хэлбэрээр тооцож байна. Мөн тодорхой хүчин зүйлийн бүтээмжийг хөдөлмөрийн, капиталын, үндсэн түүхий эд материалын, эрчим хүчний бүтээмж гэж тусгайлан тооцож байна.

Нийт бүтээмж нь бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор үйлдвэрлэлд зарцуулсан нийт зардлын нэг төгрөг тутмаас хэдэн төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснийг харуулах бөгөөд 2007 онд улсын дүнгээр нийт бүтээмжийн хэмжээ 0.78 төгрөг болж 2006 оныхоос 0.05 төгрөгөөр буурав. Эдийн засгийн салбараар авч үзвэл уул уурхай олборлох үйлдвэрлэлийн салбар, хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээний салбарт нийт бүтээмж 1.60-2.39 төгрөг байгаа нь бусад салбарынхаас харьцангуй өндөр байна. Нийт бүтээмжийн хэмжээ эдийн засгийн салбаруудаар авч үзвэл 2006 болон 2007 онд ойролцоо түвшинд, харин 2004 оны түвшнээс уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт өндөр өсөлттэй байна.

Үйлдвэрлэлийн гол хүчин зүйлс болох хөдөлмөр, капиталын ашиглалтын үр ашгийг тодорхойлох үндсэн хүчин зүйлийн бүтээмж нь 2007 онд улсын дүнгээр 3.53 төгрөг болж, 2006 онтой харьцуулахад 0.17 төгрөгөөр буурчээ. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбараар авч үзвэл цалин хөлс, капиталын ашиглалтын зардал нь бусад салбарынхаас харьцангуй бага байдаг хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар, үйлчилгээний салбарт үндсэн хүчин зүйлийн бүтээмж нь харьцангуй өндөр байна.

Товч танилцуулга |

Тодорхой хүчин зүйлийн бүтээмж болох капиталын бүтээмж 2007 онд оны үнээр 15.38 төгрөг, үндсэн түүхий эд, материалын бүтээмж 4.62 төгрөг, эрчим хүчний бүтээмж 32.99 төгрөг, хөдөлмөрийн бүтээмж (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 3261.1 мянган төгрөг болж, 2006 онтой харьцуулахад капитал, үндсэн түүхий эд материал, эрчим хүчний бүтээмж ижил түвшинд, харин хөдөлмөрийн бүтээмж 6.9 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн сан

Аж ахуйн нэгж, байгууллагын бизнес регистрийн санд 2007 оны эцсийн байдлаар 55.9 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэний 32.1 мянга буюу 57.4 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 80.1 хувийг 1-9, ажиллагчидтай, 8.8 хувийг 10-19 ажиллагчидтай, 7.3 хувийг 20-49 ажиллагчидтай, 3.8 хувийг 50-иас дээс ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна.

Аж ахуй нэгж, байгууллагын тоог 2004 оны аж ахуй нэгж, байгууллагын тоотой харьцуулхад 1-9 ажиллагчидтай нь 0.6 пунктээр, 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 2.6 пунктээр өсч, харин 10-19 ажиллагчидтай нь 14.8 пунктээр, 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 5.5 пунктээр тус тус буурсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын өсөлтийг сүүлийн дөрвөн жилийн дунджаар авч үзвэл үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа 22.1 хувь, барилга 19.3 хувь, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо 18.4 хувь, зочид буудал, зоогийн газар 15.4 хувь, уул уурхай, олборлох үйлдвэр 14.0 хувиар, тус тус өссөн байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог өнгөрсөн онтой харьцуулахад үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллагын тоо 15.8 хувиар буюу 0.4 мянга, барилгын салбарын аж ахуйн нэгж байгууллагын тоо 16.4 хувь буюу 0.2 мянгаар нэмэгдсэн байна.

ААНБ-ын регистрийн санд 2007 онд 7.0 мянган хуулийн этгээд шинээр бүртгүүлсэн байна. Эдгээрийн 5.5 мянга буюу 77.8 хувь нь Улаанбаатар хотод, 0.7 мянга буюу 10.2 хувь нь Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь, Ховд, Орхон зэрэг аймгуудад байршиж байна.

Хүний хөгжлийн индекс (ХХИ)

Монгол улсын Хүний хөгжлийн индекс (ХХИ) сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд жил дараалан тасралтгүй өсч байгаа билээ. Хэдий тасралтгүй өсч байгаа боловч олон улсын түвшинд дундаж үзүүлэлттэй орны тоонд ордог. Энэ нь нэг хүнд ногдох ДНБ харьцангуй бага байгаагаас шалтгаалж байна.

2004-2007 онуудад дундаж наслалт 2.0 жилээр, бүх шатны сургуульд суралцагчдын суралцвал зохих насны хүн амд эзлэх хувь 2.9 хувиар, нэг хүнд ногдох ДНБ 585.1 ам. доллараар өссөн нь хүний хөгжлийн индекс 0.028-аар өсөхөд нөлөөлсөн байна.

ХХИ нь хүний хөгжлийн ерөнхий түвшин, төлөв байдлыг илэрхийлдэг үзүүлэлт юм. Түүний зэрэгцээ жендэрийн тэгш байдлыг хэрхэн хангаж буйг судлах зорилгоор бие даасан хоёр өөр индексийг ашигладаг. Үүний нэг нь жендэрийн хөгжлийн индекс (ЖХИ) юм. Уг индексийн шалгуур үзүүлэлтүүд нь хүний хөгжлийн индексийг тооцдог гурван үндсэн үзүүлэлттэй ижил бөгөөд ялгаа нь эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй харьцуулан судлах боломж олгодгоороо онцлогтой. Хоёр дахь нь эмэгтэй хүний нийгэмд эзэлж буй байр суурийг эрэгтэй хүнтэй харьцуулан илэрхийлдэг жендэрийн эрх мэдлийн хэмжүүр (ЖЭМХ) юм.

Жендэрийн хөгжлийн индексийг тооцоход ашигладаг гурван үзүүлэлтийг тус тусад нь авч үзвэл эмэгтэйчүүд зарим талаараа эрэгтэйчүүдээс дутуу зарим талаараа давуу талтай байна. Тухайлбал, 2007 онд Монгол эрэгтэй хүний дундаж наслалт 63.13 жил байхад эмэгтэйчүүдийнх 70.23 жил, 7-22 насандаа сургуульд хамрагдаж буй эмэгтэйчүүд 85.0 хувь байхад эрэгтэйчүүд 76.8 хувьтай, нэг хүнд ногдох ДНБ эрэгтэйчүүдэд 2974.1 байхад эмэгтэйчүүдэд 2324.5 (PPP US\$) байна.

Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр 0.421 байгаа нь эдийн засаг, улс төрийн хүрээ болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгааг илэрхийлнэ. Хөдөлмөр эрхлэлтэнд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй өндөр байдаг ч УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүд 1990 онд 24.9 хувь байсан бол 2000 онд 11.8 хувь 2004 онд 6.6 хувь болж тус тус буурсан бөгөөд энэ хандлага шийдвэр гаргах бүх түвшинд адил байна.

Мянганы хөгжлийн зорилтын үзүүлэлт

Монгол улсын МХЗ-ын одоогоор тооцож буй 33 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийн явцаас үзэхэд үндсэн гол зорилтууд, тухайлбал бүх нийтээр бага боловсрол эзэмших; хүйсийн тэгш байдлыг сайжруулах; хүүхдийн эндэгдлийг бууруулах; байгаль орчны тогтвортой байдлыг хангах зэрэг зорилтууд 2015 он гэхэд бүрэн хэрэгжих боломжтой байна.

Харин ядуурлыг бууруулах, ХДХВ/ДОХ, хумхаа болон бусад өвчинтэй тэмцэх зэрэг зорилтууд ихээхэн хүндрэлтэй тулгахаар байна.

“Өрхийн орлого, зарлагын судалгаа”-ны дүнгээр 2006 онд нийт хүн амын 32.2 хувь нь ядуу байна. Хөдөөтэй харьцуулахад хот суурин газруудад ядуурал харьцангуй доогуур байгаа бөгөөд хотод 27.9 хувь, харин хөдөөд 37.0 хувь байна.

ҮСХ-ноос НҮБ-ын Хүүхдийн Сангийн техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд, хөгжил – 2005/2006 он” судалгааг явуулсан болно. Уг судалгааны дүнгээр Монгол улсад тав хүртэлх насны хүүхдийн 6.3 хувь нь нормоос доогуур жинтэй байгаа нь өмнөх 2000 оны судалгааны үеийнхээс 2 дахин бага байна.

Судалгааны дүнгээс үзэхэд хотын 5 хүртэлх насны хүүхдүүдийн 5.6 хувь, хөдөөний 5 хүртэлх насны хүүхдүүдийн 7.0 хувь нь зохих нормоос бага жинтэй байгаа нь хүүхдийн жин багадаа тохиолдол хөдөөд, хотоос харьцангуй их байгааг харуулсан.

Анхан шатны сургуульд суралцагсдын цэвэр харьцаа 2000 онд 95.0 хувь, 2004 онд 90.2 хувьтай байсан бол 2007 онд 92.7 хувь болж, 2004 оны түвшнээс 2.5 хувиар нэмэгджээ.

Бүх шатны боловсрол эзэмшиж байгаа хүмүүсийн хүйсийн харьцаа 1990, 1991 онуудад 1.1 байснаа 1992 - 2002 онуудад 1.2 - 1.3, 2003 оноос эхлэн 1.1 болон тогтворжиж байна.

ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ эрэгтэйчүүдийнхтэй ойролцоо байна.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсрол эзэмших болсон боловч удирдах болон шийдвэр гаргах түвшний албан тушаал дээр эмэгтэйчүүдийн төлөөлөл бага хэвээр байна. Хэдийгээр 1992 оны сонгуулиар эмэгтэйчүүд үндэсний парламентын нийт гишүүдийн 3.9 хувь, 1996 оны сонгуулиар 9.2 хувь, 2000 оны сонгуулиар 11.8 хувийн төлөөлөлтэй болж өсөх хандлагатай байсан ч 2004 оны сонгуулиар 6.6 хувь болж буурсан.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монгол улсад нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин эрчимтэй буурсан.

Өнөөгийн байдлаар Монгол улс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг гуравны хоёроор бууруулах гэсэн Мянганы хөгжлийн 1990 - 2015 онд хүрэх зорилтыг нэгэнт хангаад байна. Цаашид энэ хандлагыг хадгалах нь чухал юм.

Товч танилцуулга |

Эхийн эндэгдэл нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалтай нягт уялдаатай юм. Эхийн эндэгдэл нь эхийн нас, төрөлт хоорондын зай, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой. 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 1993 онд 259 байсан нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Харин 2007 онд улсын хэмжээнд 88 болов.

Монгол улс ДЭМБ-ын Номхон далайн Баруун эргийн Бүсийн орнуудын хувьд сүрьеэгийн өвчлөл өндөр зэрэглэлтэй 5 оронд багтдаг. Сүрьеэгийн өвчлөл сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа бөгөөд тархалтын түвшин 2004 онд 100 000 хүн амд 179 ногдож байсан бол 2007 онд 167 болж буурсан байна.

Монгол улсын хэмжээнд 21.0 сая га талбай бүхий газрыг улсын тусгай хамгаалалтад авснаар улсын нийт газар нутгийн 13.4 хувийг эзлэх боллоо. Цаашид 2015 он гэхэд нийт нутгийн 30 орчим хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах зорилттой байгаа болно.

Манай орны хувьд газар зүйн байрлал, уур амьсгалын онцлогоос шалтгаалан нийт нутгийн 90 гаруй хувийг хуурай, хагас хуурай, хуурайвтар, чийг дутмаг нутаг эзэлдэг. Ойгоор бүрхэгдсэн талбай нийт нутгийн 7.7 хувь байна.

Холбооны салбарт шинэ технологийг илүү эрчимтэй нэвтрүүлж байна. 1000 хүн ам тутамд ногдох суурин телефон цэгийн тоо 2007 онд 57 болсон бол үүрэн утас хэрэглэгчдийн тоо 447 болж ойролцоогоор 2 хүн тутмын нэг нь үүрэн утас хэрэглэгч болсон байна. Зөвхөн сүүлийн нэг жилийн хугацаанд л гэхэд үүрэн утас хэрэглэгчдийн тоо 405.0 мянган хүнээр нэмэгдсэн байна.

OVERVIEW

Population

At the end of 2007, resident population of Mongolia was a 2 million 635.2 thousand. This is an increase by 1.3 percent or 40.4 thousand since 2006. 48.7 percent of the total population is men and 51.3 percent is women in that year, giving a sex ratio at of 95.1 males per 100 females.

Migration stream to Ulaanbaatar city has not slowed down. The population was increasing year by year in Ulaanbaatar. In 2007, population density was 219.4 persons per square kilometer in Ulaanbaatar. There increased each by 11.0 percent in 2004, 6.8 percent in 2005, and 3.7 percent in 2006.

In 2007 about 60.8 percent of the total population or 1601.0 thousand persons were living in urban areas. In 2007, more than half the populations in each of Dornod, Dornogovi, Govisimber, Darkhan-Uul, and Orkhon aimags were living in urban areas. In the Tuv aimag was more than 80 percent of the population lived in rural areas.

In 2007, about 59.1 percent of the 645.7 thousand private households were in urban areas and 40.9 percent in rural areas. The population of Mongolia was 4.1 persons per household in 2007.

However the population net growth was a decrease, so in 2006 and 2007 birth was increase. The crude birth rate per 1000 population was 21.7 in 2007. This is an increase by 2.7 point since 2006. In 2007, the number of live births shows increased by 24.5 percent in 2004, 15.4 percent in 2006. The sex ratio at birth in our country was 103 in 2007. Total fertility rate was 2.0 in 2004, 1.9 in 2005, 2.1 in 2006 and 2.3 in 2007.

The crude death rate was relatively constant last years in our country. The crude death rate was 6.2 in 2007. The infant mortality rate furthermore goes down and reaches the bottom at the age group. In 2007, 16.3 thousand persons died, of which 6.1 percent were infant mortality. Crude death rate varied by aimags. In 2007, the highest crude death rate was registered in the Khuvsgul(7.1), Darkhan-Uul(6.9), Khentii(6.8), Orkhon(6.8) and the lowest in the Umnugovi(4.3), Bayan-Ulgii (4.9), Khovd (5.0), Dornogovi(5.4).

In 2007, 41.0 thousand persons were marriages, 1.8 thousand persons were divorced and 2.5 thousand children adopted. Compared with the previous year persons were divorced increased by 21.3 percent and adoption increased by 19.6 percent. Crude marriage rate increased steadily between the periods 2004-2006 and decreased in 2007. In 2007, crude marriage rate compared with the previous year decreased by 3.3 points.

The marriage was not relatively constant last years in our country. In 2005, marriage increased by 0.3 point from 2004, in 2006 marriage decreased by 0.4 point from 2005, but in 2007 marriage increased by 0.1 point from 2006.

Some social indicators for Households and population

The Government of Mongolia has been taking considerable measures focused on the high righted issues concerning with maternal and children health condition.

In 2007, the number of orphan children was 49.8 thousands but it was decreased by 3.7 percent comparing to 2004, by 5.3 percent comparing to 2005, by 2.4 percent comparing to 2006, respectively. In 2007, totally 49.8 thousands of orphan children registered and out of this 10.2 percent or 5.1 thousands were orphan children and 89.8 percent or 44.7 thousands were half orphan children. In 2007, number of orphan children increased by to 6.5 percent comparing to 2004, but it decreased by to 6.8 percent comparing to 2005, by 3.8 percent comparing to

Overview

2006. A number of half orphan children decreased by 3.4 percent comparing to 2004, by 5.1 percent comparing to 2005, by 2.3 percent comparing to 2006, respectively.

In 2007, the number of female-headed households was 72.1 thousands and it was increased by 9.8 percent comparing to 2004, by 2.6 percent comparing to 2005, but it decreased by 0.1 percent in 2006. The number of death of male population aged 18 and over had more impact on increased number of female-headed households than divorce.

In 2007, the share of female-headed households that comprises 3 family members was 50.9 percent or 36.7 thousands, the share of female-headed households that comprises 3-5 family members was 37.4 percent or 27.0 thousands, the share of female-headed households that comprises 6 family members and more was 11.7 percent or 8.4 thousands. In 2007, out of total number of female headed households, 14.7 percent has been registered in the Western region while 24.2 percent was registered in Khangai region, 19.1 percent in Central region, 9.7 percent in Eastern region and 32.3 percent in the Capital city of Ulaanbaatar, respectively.

In 2007, the number of households with 4 and more children aged below 16 was 37.9 thousands but it decreased by 18.8 percent comparing to 2004, by 10.6 percent comparing to 2005, by 5.2 percent comparing to 2006, respectively. But number of single women with children aged below 16 was 43.5 thous in 2007 but it decreased by 3.5 percent comparing to 2004, by 10.1 percent comparing to 2005, by 5.8 percent comparing to 2006. In 2007, out of total number of single mother with children under age of 16, 61.3 percent or 26.7 thousands of single mother had 3 children, 28.2 percent or 12.3 thousand of single mother was had 3- 5 children, 10.5 percent or 4.6 thousands of single mother had 6 and more children.

Labour force

Resulting from transition period from a centrally planned economy to a market economy, Mongolia faced with many challenges. For instance, the number of unemployment increased because of structural change of economy, depression of production and cease of industries as well as enterprises. Following them an employment regulation office was set up to provide employment services such as intermediating with job places and retraining. From 1992 persons who registered themselves at Labour and Social Welfare Departments (former employment office) were considered as unemployed in accordance with the international concepts and methodology. Accordingly, labour force or economically active population, labour force participation rate and unemployment rate have been estimated by national average, capital city, aimags, age groups and sex.

A main indicator that shows labour market development and economic activity of population is the labour force participation rate. This rate has decreased slightly in the past few years. In 2007, the labour force participation rate reached to 64.2 percent, a 0.2 point decline from 2004 and 2006, and a 0.7 point rise from 2005. In 2007, the number of registered persons was 29.9 thousand, dropped by 15.8 percent from 2004, and by 9.1 percent from 2005 and 2006, respectively. A fall in the number of registered unemployed in recent years was due to a rise in the number of employees and an increase in the number of persons who found jobs through the Labour and Social Welfare Departments (former employment office) at the capital city and aimags.

At the national level, a share of employed population in economically active population amounted to 97.2 percent in 2007, increasing by 0.8 point from 2004 and by 0.5 point from 2005, and by 0.4 point from 2006.

For the economic activity sectors, the number of employed population has increased in all other economic sectors except agriculture, hunting and forestry, manufacturing, real estate, business activities, and other community and social services in the past few years.

Male and female shares in economically active population and employed population have been close while the female share in the registered unemployed was higher than the males.

There has been a growth of proportion of persons with higher education or untrained persons among the unemployed registered at Labour and Social Welfare Departments in the capital city and aimags while the decline in the proportion of persons with specialized secondary or vocational education.

As of January 1, 2007, there are 128.1 thousand government employees, a 1.3 percent rise from 2004 and a 5.2 percent rise from 2005 and a 6.2 percent rise from 2006.

Average wages and salaries

Average wages and salaries sample survey has been carried out quarterly since 4th quarter of 2000 and results are estimated by gender, economic activity sector, occupation, types of organization ownership and responsibility by aimag and the capital city level. Over 163.0 thousand employees of 1035 organizations with various economic activity and ownership are covered by the sample survey, every quarter.

As of 2007, annual average wages and salary is 173.0 thousand tugrugs which is 85.8 percent higher than 2004, and 70.9 percent higher than 2005, and 35.5 percent higher than 2006.

In economic activity sectors, average salaries for transport and storage communication, education, public administration, defense, compulsory social insurgency, mining and quarrying, financial intermediation are higher than other sectors and national average.

In addition, average salaries for state enterprise higher than national average and other economic entities.

Gross domestic product

Mongolia's economic situation proceeded favorable trends and last years preserved relatively higher economic growth. Economic real growth for 2000-2003 annual average growth was 4.3 percent, but for 2004-2007 annual average growth was 9.1 percent.

2004-2007 average growth compared with previous 4 year higher by 4.8 points and this increase was achieved mainly by number of livestock from 2003 increased by 14.9 million; annual value of mining of gold was 20.9 ton, compared with annual average 2000-2003 increased by 8.7 ton; last years in information, communication technology sector 2 enterprises started activity on cellular communication operator; in manufacture, manufacture of basic metals sector manufacturing molybdenum and start to made final products.

The production of major commodities of industry and agriculture increased. For example, in industry annual average production of knitted goods, coal, gold, combed down for 2004-2007 increased by 41.6-86.8 percent, in crops production of vegetables and potatoes increased by 38.4-56.1 percent respectively.

The annual average value of GDP per capita at 2005 constant prices has reached 885.7 thousand togrogs for 2000-2003 and 1140.1 thousand togrogs for 2004-2007, it has increased by 1.3 times.

In 2007 preliminary GDP was 4557.5 billion togrogs at current prices and 3316.5 billion togrogs at constant prices of 2005. It shows an increase by 9.9 percent or by 299.1 billion togrogs compared with the previous year. This increase was achieved mainly by growth of the agriculture sector by 15.8 percent, manufacturing by 32.3 percent, construction by 22.4 percent, transport, storage and communication sector by 18.6 percent respectively. Private sector share was 52.6 percent to GDP in 1995, but in 2007 it was reached 68.4 percent accordingly.

Overview

For the preliminary estimates of 2007 of GDP by expenditure approaches, the final consumption's share in total GDP is 64.1 percent, gross capital formation is 37.6 percent and net export is -1.7 percent. Compared with 2006, the share to GDP of final consumption and gross capital formation increased by 2.8-4.5 points respectively, but the share of net export to GDP decreased by 7.3 points. In 2007, net exports or goods and services deficit are mainly influenced for this changes of the GDP composition. The speed of rise of imports was higher than the exports, moreover the expenditure of transportation, insurance and construction works' services were increased. These are mainly influenced for the goods and services deficit.

"Quarterly GDP estimation" methodology approved by NSO in 2007. In 2007 preliminary GDP by quarter shows that GDP in quarter II increase by 55.4 percent compared with previous quarter and in quarter III by 2.2 percent, in quarter IV by 11.4 percent respectively.

Input and Output Table

Due to the transition by Mongolia to the market economy, methodologies for key macro-economic indicators and estimates needed to be met international standards. In recent years, there are a considerable number of steps being undertaken towards expeditious introduction of a method for GDP estimation and compilation of national accounts.

In addition, one of important goals to be achieved by the National Statistical Office is to show the basic economic equilibrium of the country in a form of the balance upon compiling it at the macro-level, to compile Input-Output Table (IOT) on the basis of a certain frequency, to analyze the results and findings, and to make data sources to be used by policy makers broader and consistent.

It was 1963 when Mongolia compiled its first IOT while developing through the centrally planned economy system. During the system the ITO was compiled for 1966, 1970, 1977, 1983, and 1987 using the Material Product System utilized by member countries of the Council for Mutual Economic Assistance. After the transition to the market economic relations, the IOT was compiled in 1997 and 2000 on the experimental basis in accordance with the common methodology of System of National Accounts (SNA-93) and last one was derived from the Supply and Use Table in 2005.

